

# ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН 2023 ОНЫ УЛСЫН НЭГДСЭН ТАЙЛАН

Улаанбаатар хот  
2024 он

АГУУЛГА

ОРШИЛ.....	2
<b>1.ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН</b> .....	<b>3</b>
1.1.ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛСЭН ТОМООХОН АЖЛУУД .....	3
1.1.1.Газар зохион байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн чиглэлээр. ....	3
1.1.2.Суурь судалгаа, мониторингийн чиглэлээр. ....	5
1.1.3.Газрын кадастр, мэдээллийн сангийн чиглэлээр. ....	7
1.2.Газрын харилцааны салбарын хүний нөөц .....	11
1.3.Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн .....	13
хяналт, шалгалт, авсан арга хэмжээ .....	13
1.4.Өргөдөл, хүсэлт, тэдгээрийн барагдуулалтын судалгаа .....	15
1.5.Газрын маргаан, түүнийг шийдвэрлэсэн байдал .....	18
1.6.Газар эзэмших эрх болон өмчийн газраа банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдлын тайлан .....	22
1.7.Газрын зах зээлийн тойм.....	24
1.8.Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын талаарх мэдээ, тайлан .....	31
1.9.Сууц өмчлөгчдийн холбоонд ашиглуулж буй газрын тайлан .....	37
1.10.Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2024 оны төлөвлөгөө .....	39
<b>2.ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТАЙЛАН.....</b>	<b>59</b>
2.1.Газрын нэгдмэл сангийн ангилал, газар ашиглалтын төрөлд гарсан өөрчлөлт, шилжилтийн үндэслэл /Маягт ГНСТ-1, 2, 4/ .....	59
2.1.1.Хөдөө аж ахуйн газар .....	61
2.1.2.Хот, тосгон, бусад суурины газар.....	64
2.1.3.Зам, шугам сүлжээний газар .....	65
2.1.4.Ойн сан бүхий газар.....	66
2.1.5.Усны сан бүхий газар.....	67
2.2.Улсын тусгай хэрэгцээний газар /Маягт ГНСТ-3/ .....	68
2.3.Газрын нэгдмэл сангийн эрх зүйн байдлын .....	71
тайлан /Маягт ГНСТ-5/ .....	71
2.4.Газрын улсын бүртгэлийн тайлан /Маягт ГНСТ-6/ .....	74
2.5.Газар өмчлөлийн тайлан /Маягт ГНСТ-7/.....	76
2.6.Газрын төлбөр ногдуулалт, төлөлтийн тайлан /ГНСТ-8/ .....	79
2.7.Газарт учруулсан хохирлын тайлан /Маягт ГНСТ-9/.....	84
2.8. Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайлан /Маягт ГНСТ-10/ .....	90
<b>3. ДҮГНЭЛТ.....</b>	<b>96</b>

## ОРШИЛ

Газрын тухай хуулийн 26 дугаар зүйлд Газрын нэгдмэл сангийн улсын нэгдсэн тайланг жил бүр Засгийн газарт танилцуулахаар тусгасан байдаг.

Газрын нэгдмэл сангийн тайланд газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар хэрэгжүүлсэн газар зохион байгуулалтын арга хэмжээ, байгаль орчин, газрын хууль тогтоомжийн хэрэгжилт, газрын төлөв байдал, чанарт гарсан өөрчлөлт, сөрөг нөлөөлөл, түүнд өгөх дүгнэлт, газрыг зохистой ашиглах, хамгаалах талаар газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчаас хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүн, дутагдал, газрыг өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдад хуваарилсан байдал, түүний өөрчлөлт, газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал, газар ашиглалтын төрөлд гарсан өөрчлөлт, шилжилтийн үндэслэл, газрын төлбөр ногдуулалт, төлөлт зэргийг дэлгэрэнгүй тусгадаг. Эдгээр мэдээллийг Засгийн газрын 2022 оны 432 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын нэгдмэл сангийн тайлан гаргах журам”-ын дагуу улсын хэмжээнд нэгтгэн, тайлагнаж байна.

Газрын нэгдмэл сангийн улсын нэгдсэн тайлан нь тайлангийн хугацаанд газрын нэгдмэл сангийн ангилал болон газар өмч эзэмшил, ашиглалтын эрх зүйн байдал, тэдгээрийн өөрчлөлтийг гаргах, өөрчлөлтөд дүгнэлт өгөх, газрын талаар авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг тодорхойлох, цаашид газрыг өмчлөх, эзэмших, ашиглах, хуваарилах, хамгаалах, нөхөн сэргээх болон газар зохион байгуулалтын бусад арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, газрын нэгдмэл сангийн мэдээ, мэдээлэлд өөрчлөлт оруулах, улс, орон нутгийн статистик мэдээнд ашиглахад суурь материал болдог ач холбогдолтой юм.

## 1. ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН


### 1.1. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛСЭН ТОМООХОН АЖЛУУД

#### 1.1.1. Газар зохион байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн чиглэлээр.

##### Аймаг, нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 3.7.4.4-т нийслэл, Булган, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Архангай, Баянхонгор, Ховд, Говь-Алтай аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахаар тусгагдсан. Нийслэл болон Булган, Баянхонгор аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө 2022 онд батлагдаж, 2023 онд “Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал” төсөл болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймаг, “Хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах” (STREAM) төсөл, орон нутгийн төсвийн санхүүжилтээр Сэлэнгэ, Архангай аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2024 онд Хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах төслийн санхүүжилтээр Өвөрхангай аймаг, орон нутгийн санхүүжилтээр Ховд, Говь-Алтай аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Хөвсгөл, Өмнөговь аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийлгэх ажлуудыг зохион байгуулахаар ажиллаж байна.



Зураг 1.1.1.1. Аймаг, нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулсан байдал

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.7.4-ийн 5-т нийт 54 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахаар тусгагдсан.

2023 онд Баянхонгор аймгийн Баянговь, Бөмбөгөр, Эрдэнэцогт, Заг, Дорнод аймгийн Матад, Булган, Хөлөнбуйр, Баянтүмэн, Чойбалсан, Гурванзагал, Баяндун, Чулуунхороот, Баян-Уул, Завхан аймгийн Цагаанчулуут, Отгон, Алдархаан, Завханмандал, Идэр, Эрдэнэхайрхан, Яруу, Сантмаргац, Нөмрөг, Баянхайрхан, Тэс, Баянтэс, Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Наран, Дарьганга, Онгон, Баяндэлгэр, Асгат, Эрдэнэцагаан, Халзан, Түвшинширээ, Уулбаян, Мөнххаан, Түмэнцогт, Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Баянгол, Орхон, Сант, Сайхан, Баруунбүрэн, Жавхлант, Хушаат, Шаамар, Зүүнбүрэн, Сүхбаатар, Цагааннуур, Алтанбулаг, Түшиг, Ерөө, Хүдэр, Мандал, Ховд аймгийн Зэрэг, Эрдэнэбүрэн, Мянгад, Увс аймгийн Цагаанхайрхан, Давст, Төв аймгийн Эрдэнэсант, Лүн, Заамар, Батсүмбэр, Борнуур, Эрдэнэ, Сэргэлэн, Хэнтий аймгийн Баян-Овоо, Баян-Адарга, Норовлин, Биндэр, Баянмөнх, Хэрлэн, Дархан, Галшар зэрэг нийт 9 аймгийн 74 суманд нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулсан байна.

2024 онд 7 аймгийн 78 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг орон нутгийн төсвийн хөрөнгөөр болон олон улсын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр боловсруулж, батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.


Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилт:

Улсын хэмжээнд 110 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газарт 1149 байршил, 6142.2 мянган га газарт төлөвлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилт нь 5.02 хувьтай байна.

*Хүснэгт 1.1.1.1. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт (аймгаар)*

Д/д	Аймгийн нэр	Төлөвлөгөөг хэрэгжүүлсэн сумдын тоо	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу 2023 онд хэрэгжсэн арга хэмжээ	
			Байршлын тоо	Газрын хэмжээ /мян.га/
1	Архангай	5	115	121.9
2	Баян-Өлгий	1	-	-
3	Баянхонгор	8	48	439.6
4	Булган	15	104	1,178.7
5	Говь-Алтай	3	258	2,116.6
6	Говьсүмбэр	3	133	456.1
7	Дархан-Уул	1	5	0.013
8	Дорноговь	4	18	211.8
9	Дорнод	4	-	-
10	Дундговь	15	109	396.1
11	Завхан	3	20	360.5
12	Орхон	1	-	-
13	Өвөрхангай	3	9	7.3
14	Өмнөговь	15	152	698.5
15	Төв	4	-	-
16	Увс	6	168	15.0
17	Ховд	5	-	-

18	Хөвсгөл	3	-	-
19	Хэнтий	11	10	139.7
<b>Нийт</b>		<b>110 сум</b>	<b>1149</b>	<b>6,142.2</b>



Зураг 1.1.1.2. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлсэн сумдын мэдээлэл


### 1.1.2. Суурь судалгаа, мониторингийн чиглэлээр.

Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийг тогтсон хугацаанд тогтмол хянах, өөрчлөлтийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, ашиглалтыг тохируулах, үнэлэлт дүгнэлт өгөх, холбогдох мэдээллийн санг үүсгэн хэрэглэгчдийг мэдээллээр хангах, бэлчээрийн газрын хөрсийг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахад суурь мэдээлэл болгох зорилгоор бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг Улсын хэмжээнд 8 дахь жилдээ зохион байгуулан ажиллаж байна.

Бэлчээрийн газарт фотомониторинг хийх аргын давуу тал нь богино хугацаанд нэг дор олон мэдээллийг цуглуулах, хэрэглэхэд энгийн, зардал багатай, сэргэн ургалт, доройтлын урт, богино хугацааны өөрчлөлтийг харах боломжтой юм.

2023 оны байдлаар 21 аймгийн 319 сум, нийслэлийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт бэлчээрийн газрыг төлөөлсөн нийт 5313 фотомониторингийн цэг байгаагаас 2023 онд 5158 цэгт хээрийн судалгаа хийж, бэлчээрийн төлөв байдлыг

үнэлэн Газрын мониторингийн цахим системд судалгааны үр дүнг оруулж, <https://egazar.gov.mn/map> цахим хуудсаар хэрэглэгчдэд нээлттэй хүргэж байна.



Зураг 1.1.2.1. 2023 оны бэлчээрийн газрын төлөв байдал.

Хүснэгт 1.1.2.1. Бэлчээрийн төлөв байдлын ангиллын хувиар харуулсан байдал

Түвшин	Бэлчээрийн төлөв байдлын ангилал	Хандлага (2017-2023 он)	Бэлчээрийн газрын төлөв байдал, өөрчлөлт						
			2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
I	Байгалийн унаган төлөв байдлаа алдаагүй		30%	19%	17%	11.8%	11.8%	11%	11%
II	Байгалийн унаган төлөв байдлаас бага зэрэг		54%	38%	35%	43.1%	44.6%	45.2%	45.7%
III	Бэлчээрийн ургамлын бүтэц, бүрэлдэхүүн болоод бүтээмжийн хувьд нилээд өөрчлөгдсөн		12%	19%	22%	21.4%	18.2%	17.6%	19.6%
IV	Бэлчээр хүчтэй доройтож, унаган зүйл ургамлууд устаж, түрэгч ургамлууд нэмэгдсэн		4%	20%	21%	17.5%	17.5%	16%	17%

V	Бэлчээр маш хүчтэй өөрчлөгдсөн		0%	4%	5%	6.2%	7.9%	10.2	6.6
	<b>Нийт</b>		<b>100%</b>	<b>100%</b>	<b>100%</b>	<b>100%</b>	<b>100%</b>	<b>100%</b>	<b>100%</b>


Бэлчээрийн газрын төлөв байдал, мониторингийн 2017 оны үр дүнг 2023 он хүртэлх үр дүнтэй харьцуулахад сүүлийн 4 жилд бэлчээрийн төлөв байдал нь 3-5 дугаар түвшинд шилжих өөрчлөлтүүд гарсан байна.

Бэлчээрийн фото мониторингийн 2023 оны судалгааны үр дүнд 569 мониторингийн цэг буюу 11% нь байгалийн унаган төрхөө алдаагүй, 2356 мониторингийн цэг буюу 45.7% нь бага зэрэг өөрчлөгдсөн, 1012 мониторингийн цэг буюу 19.6% нь дунд зэрэг өөрчлөгдсөн, 879 мониторингийн цэг буюу 17% нь хүчтэй өөрчлөгдсөн, 342 мониторингийн цэг буюу 6.6% нь маш хүчтэй өөрчлөгдсөн байна.

### 1.1.3. Газрын кадастр, мэдээллийн сангийн чиглэлээр.

#### Газрын харилцааны КИОСК төхөөрөмж

Газрын харилцааны талаарх төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, түргэн шуурхай хүргэх зорилгоор цахим машиныг Улсын хэмжээнд үе шаттайгаар нэвтрүүлсэн бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар Хөвсгөл, Архангай, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Төв, Дундговь, Өмнөговь, Хэнтий аймаг болон Улаанбаатар хотод нийт 39 төхөөрөмжийг хэрэглээнд нэвтрүүлж, улсын хэмжээнд 50 киоск төхөөрөмжөөр иргэн, хуулийн этгээдэд газартай холбоотой үйлчилгээг үзүүлж байна.



Зураг 1.1.3.1. Улсын хэмжээнд киоск төхөөрөмжийг нэвтрүүлсэн байдал

Газрын харилцааны киоск төхөөрөмж нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад газрын харилцаатай холбоотой нийт 70 орчим төрлийн үйлчилгээ үзүүлэх боломжтой ба 52 төрлийн өргөдлийг цахимаар өгөх, 12 төрлийн мэдээлэл, лавлагаа, тодорхойлолтыг үнэ төлбөргүй хэвлэн авах, мөн цахим хүсэлт,



өргөдлийнхөө шийдвэрлэлтийн явцыг шалгах, цахим гэрээ, гэрчилгээ үүсгэх, газрын төлбөр шалгах, газрын төлбөрөө QR-аар төлөх зэрэг үйлчилгээг үзүүлж байна.

Энэхүү киоск машин нэвтэрснээр газрын харилцааны салбар дахь шаардлагагүй шат дамжлагыг цөөлөх, дарааллыг бууруулах, төрийн үйлчилгээг ил тод, түргэн шуурхай хүртээмжтэй болгоход томоохон ахиц гарч байгаа юм.

Хаягийн мэдээллийн нэгдсэн систем

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 180 дугаар тогтоолоор “Хаягийн мэдээллийн систем”-ийг улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд тухайн системийг хэрэглээнд нэвтрүүлснээр нийт 91341 гудамж, 255392 зам, 1317294 нэгж талбар, 971701 орц гарц, 541632 барилгыг бүртгэсэн.

*Хүснэгт 1.1.3.1. Хаягийн мэдээллийн системд бүртгэгдсэн мэдээлэл*

Д/д	Улсын хэмжээнд	Гудамж	Нэгж талбар			Барилга	Орц гарц
			Нийт	Газар зүйн нэрээс хаяг олгосон	Суурьшлын бүс дэх		
1	21 аймаг	50683	738787	175906	562881	380669	449200
2	Нийслэл	40658	578507	2793	575714	160963	522501
<b>Нийт</b>		<b>91341</b>	<b>1317294</b>	<b>178699</b>	<b>1138595</b>	<b>541632</b>	<b>971701</b>

*Хүснэгт 1.1.3.2. Нийслэл, 9 дүүргийн хэмжээнд Хаягийн мэдээллийн системд бүртгэгдсэн мэдээлэл*

Д/д	Дүүргийн нэр	Гудамж	Нэгж талбар			Барилга	Орц гарц
			Нийт	Газар зүйн нэрээс хаяг олгосон	Суурьшлын бүс дэх		
1	Багануур	1211	32062	262	31800	3459	31085
2	Багахангай	976	12688	3	12685	423	13459
3	Баянгол	600	14132		14132	13585	11343
4	Баянзүрх	9935	130418	5	130413	41466	110222
5	Налайх	2469	34081	2468	31613	6960	29777
6	Сонгинохайрхан	13084	187579	9	187570	3752	181255
7	Сүхбаатар	4891	63983	45	63938	30838	56521
8	Хан-Уул	4124	52268	0	52268	23532	46156
9	Чингэлтэй	3368	48503	1	48502	36948	42683
<b>Нийт</b>		<b>40658</b>	<b>575714</b>	<b>2793</b>	<b>572921</b>	<b>160963</b>	<b>522501</b>

*Хүснэгт 1.1.3.3. 21 аймгийн хэмжээнд Хаягийн мэдээллийн системд бүртгэгдсэн мэдээлэл*

Д/д	Аймгийн нэр	Гудамж	Нэгж талбар			Барилга	Орц гарц
			Нийт	Газар зүйн нэрээс хаяг олгосон	Суурьшлын бүс дэх		
1	Архангай	1943	29834	4841	24993	16430	23763
2	Баян-Өлгий	1541	26649	2945	23704	39634	22347
3	Баянхонгор	1420	30806	9078	21728	11474	21297

4	Булган	2965	39831	15605	24226	18595	14496
5	Говь-Алтай	2259	20840	10009	10831	11935	9031
6	Говьсүмбэр	1698	13434	1139	12295	2895	13550
7	Дархан-Уул	3515	29948	7643	22305	16486	17335
8	Дорноговь	2109	35817	9859	25958	15098	24092
9	Дорнод	3279	52350	7106	45244	14661	45038
10	Дундговь	1182	24246	5416	18830	5309	16742
11	Завхан	1473	27500	5195	22305	19444	22457
12	Өвөрхангай	2665	37327	10414	26913	20537	13526
13	Өмнөговь	2516	34585	9921	24664	11937	12602
14	Орхон	3789	24281	635	23646	22177	10195
15	Сүхбаатар	1339	10677	216	10461	8997	9071
16	Сэлэнгэ	3871	75952	10904	65048	30649	70669
17	Төв	4361	106640	41480	65160	22775	35044
18	Увс	1732	23696	5857	17839	19166	13040
19	Ховд	1815	23424	3880	19544	19944	18295
20	Хөвсгөл	2989	40321	6657	33664	38134	26394
21	Хэнтий	2222	30629	7106	23523	14392	10216
<b>НИЙТ</b>		<b>50683</b>	<b>738787</b>	<b>175906</b>	<b>562881</b>	<b>380669</b>	<b>449200</b>


Барилга, хот байгуулалтын сайд, Цахим хөгжил, харилцааны холбооны сайдын 2023 оны 119/А/46 дугаар тушаалаар хамтарсан ажлын хэсэг байгуулж, “Хаягжуулалтын ажлын үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан бөгөөд улсын хэмжээнд хаягийн мэдээллийн системийг бүрэн нэвтрүүлэхэд хууль, эрх зүйн орчныг сайжруулах, зардлын асуудлыг шийдвэрлэх, өгөгдөл мэдээллийг нэгтгэх, засварлах, мэдээллийн сангийн бүтэц, зохион байгуулалтыг нарийвчлах, дундын мэдээллийн санг байгуулах, салбар хоорондын уялдааг хангах зэрэг ажлыг зохион байгуулсан.

#### Хот байгуулалтын кадастрын чиглэлээр

Хот байгуулалтын кадастр нь хот байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл хийхэд зайлшгүй шаардлагатай мэдээлэл бүхий мэдээллийн сан юм.


Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/-ийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны А/137 дугаар тушаалаар 21 аймгийн хэмжээнд нэвтрүүлсэн.

Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/-ийн олон нийтэд зориулсан “Нээлттэй мэдээлэл” цэснээс иргэн, хуулийн этгээд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран барилга байгууламж, инженерийн болон нийгмийн дэд бүтэц, тохижилт, ногоон байгууламж, орон зайд суурилсан өгөгдөл мэдээллийг авах боломжтой болсон.



Зураг. 1.1.3.2. Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/-ийн нээлттэй мэдээлэл цэснээс харах боломжтой мэдээлэл

Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/- ээр дамжуулан иргэн, хуулийн этгээд барилга барих хүсэлтээ гаргахаас эхлээд архитектур төлөвлөлтийн даалгавар, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гаргах зэрэг шат дараалсан үйл ажиллагааг цахимаар олгох, хүлээн авах боломжтой болсон.




Зураг 1.1.3.3. Хот байгуулалтын кадастрын цахим системд хандах схем

Улсын хэмжээнд **500,000** гаруй барилгын мэдээллийн санг үүсгэн газар болон үл хөдлөх, эд хөрөнгийн нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлснээр гурав болон дөрвөн /3D, 4D/ хэмжээст кадастрын мэдээллийн нэгдсэн системийг байгуулах суурь бүрдэх юм.

**1.2.ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ**

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар болгон өөрчилж, Монгол Улсын Ерөнхий Сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллахаар “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны захирамжаар 93 орон тоотойгоор 3 газар, 10 нэгжтэйгээр бүтцийн өөрчлөлтийг шинэчлэн баталсан.




Зураг 1.2.1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын бүтэц

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар нь салбарыг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах, Монгол Улсын газрын нэгдмэл сан, газар зохион байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг болон орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар нэгдсэн бодлогыг олон улсад нэвтэрсэн техник технологи, инновацыг нутагшуулах, хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, зохион байгуулах, төрийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх, Монгол Улсын нийт газар нутгийн бодит нөөц, чадамжид суурилсан салбар хоорондын уялдааг хангасан нэгдсэн төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх, газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх, байрлалд суурилсан орон зайн өгөгдөл мэдээллийн менежментийг нэвтрүүлж, дэвшилтэт техник, технологид тулгуурлан үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтэц байгуулах асуудлаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага юм.

Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д зааснаар Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь аймаг, нийслэл, дүүрэгт газрын асуудал эрхэлсэн алба, суманд газрын даамалтай нэгдмэл төвлөрсөн удирдлагын тогтолцоотой байхаар, мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.6-д “Засгийн газраас тогтоосон хязгаарт багтаан аймаг, нийслэл, дүүргийн газрын албаны бүтэц, орон тоог батлах”-аар хуульчилсан байдаг.

Хууль тогтоомжийн хүрээнд газрын даргын 2023 оны Б/49 дүгээр тушаалаар нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал, зэрэглэл, жагсаалт, 2023 оны Б/10 дугаар тушаалаар аймгуудын ГХБХБГ-ын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтыг шинэчлэн баталсан.

Одоогийн байдлаар салбарын хэмжээнд нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба 245, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар 444, сумдад газрын даамал 362, нийт 1144 албан хаагч, үүнээс төрийн захиргааны албан тушаалын 988, төрийн үйлчилгээний албан тушаалын 156 албан хаагч ажиллаж байна.




Зураг 1.2.2. Салбарын хэмжээнд ажиллаж байгаа албан хаагчийн тоог ангилан харуулсан байдал

Мөн Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 365 дугаар тогтоолоор агентлагийн 19 албан тушаалын тодорхойлолтыг шинээр, 2023 оны 367 дугаар тогтоолоор агентлагийн 29 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлах зөвшөөрөл олгосны дагуу агентлагийн даргын 2023 оны 138, 139 дүгээр тушаалаар баталсан.

2023 оны 366 дугаар тогтоолоор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын улсын (ахлах) байцаагчийн 5 албан тушаалын тодорхойлолт, 368 дугаар тогтоолоор 2 албан тушаалын тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулан батлах зөвшөөрөл, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 295, 296 дугаар тогтоолоор нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны 4 албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл олгосон бөгөөд томилох эрх бүхий албан тушаалтан батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Салбарын төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, хөгжүүлэх чиглэлээр 2023 оны сургалт, хөгжлийн төлөвлөгөөг 4 дэд хэсэгт 32 арга хэмжээ, нэмэлт 13 ажил төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллалаа.



Зураг 1.2.3. Албан хаагчдын сургалтад хамрагдсан байдал

### 1.3. ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, АВСАН АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 79 дүгээр тогтоолыг үндэслэн Барилга, хот байгуулалтын яамны салбарын ерөнхий байцаагчийн баталсан 2023 оны 02-00/12 дугаар удирдамжаар төлөвлөгөөт хяналт шалгалт, Салбарын хяналтын газрын ерөнхий байцаагчийн баталсан 2023 оны 02-00/05, 02-00/06, 02-00/06 дугаартай удирдамжаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, Салбарын ерөнхий байцаагчийн болон улсын ахлах байцаагчийн баталсан 43 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай, Газрын тухай, Хот байгуулалтын тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, Геодези зураг зүйн тухай, Хаягжуулалтын тухай, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийж холбогдох арга хэмжээг авсан.

#### **Төлөвлөгөөт хяналт шалгалт.**

Салбарын ерөнхий байцаагчийн баталсан хяналт шалгалтын нэгдсэн 02-00/12 дугаартай удирдамжийн хүрээнд нийслэлийн хэмжээнд 97 объектод газар дээр нь хяналт шалгалт хийж 139 зөрчил илрүүлж, 91 зөрчил арилгуулсан ба хяналт шалгалтын хүрээнд улсын байцаагчийн хугацаатай 6 албан шаардлага, улсын байцаагчийн 5 зөвлөмжийг хүргүүлэн зөрчлийг арилгуулсан, 1 иргэн, 3 хуулийн этгээдэд 1130.0 мянган төгрөгийн арга хэмжээ тооцон барагдуулж зөрчлийн үр дагаврыг арилгах эрх бүхий албан тушаалтны даалгавар хүргүүлэн, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж биелэлтийг хангуулсан. 21 аймгийн хэмжээнд төлөвлөгөөт

хяналт шалгалтыг 239 объектод хяналт шалгалт хийж 1014 зөрчил илрүүлж, 419 зөрчил арилгуулсан арга хэмжээ авч ажилласан байна. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 166 удаагийн албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

**Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар.**

Барилга, хот байгуулалтын яамны салбарын ерөнхий байцаагчийн баталсан 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 02-00/06, 02-00/07 дугаартай удирдамжуудын хүрээнд нийслэлийн хэмжээнд 12645 объектод хяналт шалгалт хийж 2545 зөрчлийг илрүүлсэн.

Илэрсэн зөрчлийг арилгуулахаар Нийслэлийн боловсролын газарт /нийт 18 барилга/ 02-13-04/16/01, 134-р цэцэрлэгт 02-13-04/16/02, 145-р цэцэрлэгт 02-13-04/017/03, Хан-Уул дүүргийн ЗДТГ-т 02-13-04/017/04, 149-р цэцэрлэгт 02-13-04/018/05, Хүрээ амаржих газарт 02-13-04/018/06, Сүхбаатар дүүргийн ЗДТГ-т 02-13-04/018/07, 31-р сургуульд 02-13-04/018/08, 12-р сургуульд 02-13-04/022/09, 76-р сургуульд 02-13-04/022/10, 62-р сургуульд 02-13-04/022/11, 28-р сургуульд 02-13-04/020/12, Эрдмийн өргөө цогцолбор сургуульд 02-13-04/020/13, Баянгол дүүргийн ЗДТГ-т 02-13-04/020/14, Нийслэлийн эрүүл мэндийн газарт 02-13-04/019/15, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн газарт 02-13-04/019/16, Налайх дүүргийн ЗДТГ-т 02-13-04/019/17, 172-р цэцэрлэгт 02-13-04/021/18, 97-р сургуульд 02-13-04/021/19 дугаартай зөвлөмжийг хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Шалгалтын явцад илэрсэн зөрчилд нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албанд газар эзэмших гэрээний биелэлтийг талууд жил бүр дүгнэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар 5 заалт бүхий 02-13-04/16/20 дугаартай улсын (ахлах) байцаагчдын хамтарсан зөвлөмжийг хүргүүлсэн.

21 аймгийн хэмжээнд 3099 хяналт шалгалт хийгдэж, 603 зөрчил илрүүлж, 354 зөрчил арилгуулсан байна. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 112 удаагийн албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

**Төлөвлөгөөт бус хяналт шалгалт.**

Салбарын ерөнхий байцаагчийн болон Улсын ахлах байцаагчийн баталсан 43 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд давхардсан тоогоор 146 иргэн, 396 хуулийн этгээдэд хяналт шалгалтыг хийж холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар 18 улсын байцаагчийн дүгнэлт, улсын байцаагчийн зөрчил арилгуулах 19 албан шаардлагыг тус тус хүргүүлж 18 зөрчлийг арилгуулсан ба тавьсан шаардлагыг биелүүлээгүй 1 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулинд заасны дагуу шийтгэл ногдуулан, Захиргааны хэргийн шүүхэд шилжүүлэн албадан гүйцэтгүүлэхээр шийдвэрийг гаргуулсан.

Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 2023 оны 02-00/24 дүгээр удирдамжийн хүрээнд Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн 40, 50 мянгатын орон сууцны өргөтгөлийн барилгын ашиглалтын төлөв байдалд хяналт шалгалтыг хийсэн.

Нийт өргөтгөлийн 197 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас эрх бүхий этгээдийн шийдвэргүй, газар эзэмших, ашиглах эрхийн гэрээ, гэрчилгээгүй 187 буюу 94.9%, орон сууцны зориулалт өөрчлөх тушаалгүй 150 буюу 76.1%, газар ашигласны төлбөр төлөөгүй 181 буюу 91.8% байна. Мөн 18 сууц өмчлөгчдийн холбооноос эрх бүхий Засаг даргын шийдвэргүй, газар ашиглуулах гэрээгүй, газрын хэмжээ, байршил, заагийг харуулсан нэгж талбарын зураггүй, улсын бүртгэлийн дугаар аваагүй 5 буюу 34.0%, газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгүүлээгүй 10 буюу 55.5% байна.

Хяналт шалгалтаар нийт 523 зөрчил илэрсэн ба үүний 192 буюу 36.7% нь шийдвэргүй, газар эзэмших, ашиглах эрхийн гэрээ, гэрчилгээгүй, 150 буюу 28.7% нь орон сууцны зориулалт өөрчлөх Улаанбаатар хотын ерөнхий менежерийн тушаалгүй, 181 буюу 34.6% нь газар ашигласны төлбөр төлөөгүй байна.

Барилга, хот байгуулалтын яамны Салбарын хяналтын газарт авах арга хэмжээний санал хүргүүлсэн. Мөн салбарын хяналтын газрын 2023.10.10-ны өдрийн 1/3651, 1/3652 тоот албан бичгийг нийслэлийн Засаг дарга, Онцгой байдлын ерөнхий газар, Сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөл ТББ-д тус тус хүргүүлж ажилласан.

21 аймгийн хэмжээнд 538 иргэн, хуулийн этгээдэд хяналт шалгалт хийж, 634 зөрчлийг илрүүлж, 460 зөрчил арилгуулсан байна. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 48 удаагийн албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

### **Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хүрээнд**

Нийслэлийн хэмжээнд 50 иргэн, 23 хуулийн этгээдэд нийт 73 хэрэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж үүнээс татгалзсан 3 иргэн байна.

Зөрчил үйлдсэн 70 иргэн, хуулийн этгээдэд 112.724.0 мянган төгрөгийн шийтгэл оногдуулж барагдуулсан байна. Зөрчлийн үр дагаврыг арилгах эрх бүхий албан тушаалтны даалгавар 70 хүргүүлсэн ба хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. 21 аймгийн хэмжээнд 306 иргэн, хуулийн этгээдэд 221.370.0 мянган төгрөгийн торгууль оногдуулж 125.760.0 мянган төгрөг барагдуулсан байна. Нийт улсын хэмжээнд 376 иргэн, хуулийн этгээдэд 334.094.0 мянгат төгрөг ногдуулж ажилласан байна.

## **1.4.ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТ, ТЭДГЭЭРИЙН БАРАГДУУЛАЛТЫН СУДАЛГАА**

Газрын кадастрын мэдээллийн санд нийт 1,900,666 өргөдөл бүртгэгдсэнээс шинээр газар өмчлөх 40348, шинээр газар эзэмших хүсэлт 57734, шинээр газар ашиглах 190, газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх 24644, барьцаанд бүртгүүлэх, чөлөөлөх хүсэлт 14615, газрын зориулалт өөрчлөх 430, эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах 4482, талбайн хэмжээ өөрчлөх 3124, төрөөс нөхөн олговортойгоор эргүүлэн авах 1168, эзэмшил газраа хэсэгчлэн шилжүүлэх 3122, газрын эрх дуусгавар болгох 419, шүүхийн шийдвэрээр эрх цуцлах ба сэргээх 82, эзэмшил газраа нэгтгэх 353, газрын байршил өөрчлөх 966, газрын кадастрын мэдээллийн санд нөхөн бүртгүүлэх 144960, хамтран эзэмшигч нэмэх, хасах 134 хүсэлтийг тус тус хүлээн авч бүртгэсэн байна.





Зураг 1.4.1. Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй хүсэлтийн төрөл, тэдгээрийн тоо.

Тайлант онд 21 аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 129173 хүсэлт ирүүлснээс 100003 /77.4%/ хүсэлтийг шийдвэрлэж, 29170 /22.5%/ хүсэлт шийдвэрлэгдээгүй байна.

Хүснэгт 1.4.1. Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй хүсэлтийн шийдвэрлэгдсэн байдал.

Д/д	Аймаг, нийслэлийн нэр	Нийт хүсэлтийн тоо	Үүнээс	
			Шийдвэрлэгдсэн хүсэлтийн тоо	Шийдвэрлэгдээгүй хүсэлтийн тоо
1	Архангай	2530	1934	596
2	Баян-Өлгий	2956	2428	528
3	Баянхонгор	2266	2160	106
4	Булган	5433	5320	113
5	Говь-Алтай	1762	1619	143
6	Говьсүмбэр	379	378	1
7	Дархан-Уул	2921	2378	543
8	Дорноговь	2662	2551	111
9	Дорнод	2594	2120	474
10	Дундговь	1295	1118	177
11	Завхан	2126	1549	577

12	Орхон	3613	2992	621
13	Өвөрхангай	3743	2967	776
14	Өмнөговь	2981	2024	957
15	Сүхбаатар	1239	1212	27
16	Сэлэнгэ	6531	4334	2197
17	Төв	10678	10282	396
18	Увс	3721	1651	2070
19	Ховд	2212	1486	726
20	Хөвсгөл	4544	3314	1230
21	Хэнтий	4007	2764	1243
22	Улаанбаатар	58980	43422	15558
<b>Нийт</b>		<b>129173</b>	<b>100003</b>	<b>29170</b>

Өргөдөл, хүсэлтийг шийдвэрлээгүй нийтлэг шалтгаан нь тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт шинээр газар эзэмших, өмчлөх хүсэлт гаргасан, бичиг баримтын зөрчилтэй, бичиг баримтын бүрдүүлэлт дутуу, хүсэлт ирүүлсэн газар бусдад олгогдсон газартай давхардсан, инженерийн шугам сүлжээ бүхий газар, авто замын зурвас газарт орсон, үерийн аман дээр газар эзэмших, өмчлөх, ашиглах хүсэлт гаргасан, эзэмшиж байгаа газраа өмчлөхөөр хүсэлт гаргасан боловч Газрын кадастрын мэдээллийн санд кадастрын зураг нь бодит хашаалсан газрын хэмжээнээс зөрүүтэй зэрэг шалтгаанаас өргөдөл, хүсэлтийг шийдвэрлээгүй байна.

Тайлант оны байдлаар улсын хэмжээнд Газрын кадастрын мэдээллийн сангаар дамжуулан нийт 72237 хүсэлт ирүүлснээс 53318 хүсэлтийг шийдвэрлэж, 18919 хүсэлтийг цуцалж, буцаасан байна.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт хүсэлт гаргах, баримт материалын бүрдэл дутуу байгаагаас шалтгаалан цахим системээр ирүүлсэн хүсэлтийг буцаасан байна.

Хүснэгт 1.4.2. 21 аймгийн хэмжээнд цахимаар ирүүлсэн хүсэлтийн тоо.

Д/д	Аймгийн нэр	Нийт цахим хүсэлтийн тоо	Үүнээс			
			Шийдвэрлэсэн	Өргөдөл үүссэн боловч шийдээгүй	Цуцалсан	Хянаагүй хүлээгдэж байгаа
1	Архангай	893	301	361	215	16
2	Баян-Өлгий	3898	131	3314	402	51
3	Баянхонгор	2341	802	807	657	75
4	Булган	6959	2477	3261	1096	125
5	Говь-Алтай	1677	832	701	111	33
6	Говьсүмбэр	1181	118	806	250	7
7	Дархан-Уул	6347	1088	4266	927	66
8	Дорноговь	323	245	41	36	1
9	Дорнод	2074	167	888	978	41
10	Дундговь	1977	1409	461	105	2
11	Завхан	323	131	41	113	38
12	Орхон	2908	580	1620	689	19

13	Өвөрхангай	2407	68	1989	324	26
14	Өмнөговь	1810	694	472	570	74
15	Сүхбаатар	793	86	517	121	69
16	Сэлэнгэ	11084	2107	7097	1667	213
17	Төв	5718	1565	2044	2040	69
18	Увс	1075	139	834	60	42
19	Ховд	818	129	550	66	73
20	Хөвсгөл	9857	3365	5465	839	188
21	Хэнтий	284	62	89	89	44
<b>Нийт</b>		<b>64747</b>	<b>16496</b>	<b>35624</b>	<b>11355</b>	<b>1272</b>

Хүснэгт 1.4.3. Нийслэлийн хэмжээнд цахимаар ирүүлсэн хүсэлтийн тоо.

Д/д	Дүүргийн нэр	Нийт цахим хүсэлтийн тоо	Үүнээс			
			Шийдвэрлэсэн	Өргөдөл үүссэн боловч шийдээгүй	Цуцалсан	Хянаагүй хүлээгдэж байгаа
1	Багануур	26	13	1	12	0
2	Багахангай	18	16	0	2	0
3	Баянгол	95	12	0	83	0
4	Баянзүрх	691	101	5	576	9
5	Налайх	118	5	0	112	1
6	Сонгинохайрхан	746	99	3	642	2
7	Сүхбаатар	331	17	0	221	93
8	Хан-Уул	338	32	2	271	33
9	Чингэлтэй	307	0	14	293	0
<b>Нийт</b>		<b>2670</b>	<b>295</b>	<b>25</b>	<b>2212</b>	<b>138</b>

Цаашид Газрын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө зэргийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад танилцуулах ажлыг тогтмол зохион байгуулж байх шаардлагатай юм.

### 1.5.ГАЗРЫН МАРГААН, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

2023 оны байдлаар 3572 газрын зөрчил, маргаан гарснаас газар эзэмшихтэй холбоотой 1676 /46.9%/, газар өмчлөхтэй холбоотой 638 /17.9%/, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэстэй холбоотой 1005 /28,1%/, газар ашиглахтай холбоотой 253 /7%/ маргаан тус тус гарсан байна. Газрын зөрчил, маргааныг шийдвэрлэсэн болон шийдвэрлээгүй төрлөөр аймаг, нийслэлийн тоон үзүүлэлтээр нэгтгэн харуулав.

Хүснэгт 1.5.1. Газрын зөрчил, маргаан шийдвэрлэсэн байдал /аймаг, нийслэлээр/

№	Аймгийн нэр	Маргааны тоо	Үүнээс	
			Шийдвэрлэсэн	Шийдвэрлэгдээгүй

		Эзэмших	Өмчлөх	Хилийн цэсийн	Ашиглах	Эзэмших	Өмчлөх	Хилийн цэсийн	Ашиглах	Эзэмших	Өмчлөх	Хилийн цэсийн	Ашиглах
1	Архангай	51	7	7	1	31	3	0	1	20	4	7	0
2	Баянхонгор	12	9	5	0	5	9	5	0	7	0	0	0
3	Баян-Өлгий	46	4	0	23	44	4	0	23	2	0	0	0
4	Булган	119	15	1	2	115	12	1	2	4	3	0	0
5	Говь-Алтай	98	6	21	0	96	0	9	0	2	6	12	0
6	Говь-Сүмбэр	4	0	0	0	2	0	0	0	2	0	0	0
7	Дархан-Уул	17	3	1	2	15	3	1	0	2	0	0	2
8	Дорнод	20	22	0	0	18	20	0	0	2	2	0	0
9	Дорноговь	38	5	48	0	36	5	46	0	2	0	2	0
10	Дундговь	21	2	2	0	17	2	0	0	4	0	2	0
11	Завхан	16	4	280	0	11	2	12	0	5	2	268	0
12	Орхон	15	8	36	0	15	8	6	0	0	0	30	0
13	Өвөрхангай	2	0	2	0	2	0	1	0	0	0	1	0
14	Өмнөговь	41	320	140	0	35	276	5	0	6	44	135	0
15	Сүхбаатар	6	21	3	4	6	18	3	4	0	3	0	0
16	Сэлэнгэ	69	73	86	206	60	72	83	206	9	1	3	0
17	Төв	119	48	141	0	114	37	128	0	5	11	13	0
18	Увс	53	0	13	10	53	0	13	10	0	0	0	0
19	Ховд	67	22	0	3	54	17	0	0	13	5	0	3
20	Хөвсгөл	43	6	10	0	43	6	10	0	0	0	0	0
21	хэнтий	17	26	8	2	14	20	3	2	3	6	5	0
22	Улаанбаатар	802	37	201	0	268	31	44	0	534	6	157	0
	<b>Дүн</b>	<b>1676</b>	<b>638</b>	<b>1005</b>	<b>253</b>	<b>1054</b>	<b>545</b>	<b>370</b>	<b>248</b>	<b>622</b>	<b>93</b>	<b>635</b>	<b>5</b>

2023 онд нийт 3572 маргаан гарсан байх бөгөөд шийдвэрлэсэн болон шийдвэрлэгдээгүй байдал дараах байдалтай байна. Үүнд:


Нийслэлийн хэмжээнд тухайн онд газар эзэмших, өмчлөх, ашиглах, хилийн цэстэй холбоотой асуудлаар нийт 1040 зөрчил, маргаан гарсан байна. Үүнээс Захиргааны болон Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нийт 191 хэрэг хянагдсанаас шийдвэрлэсэн 183, шийдвэрлэгдээгүй 8 хэрэг байна.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/321, А/394, А/858 дугаар захирамжийн хүрээнд нийслэлийн хэмжээнд 2778 зөрчил арилгахаар төлөвлөснөөс хэрэгжилтийг 100% хангаж ажилласан байна.

Аймгуудад тухайн онд эзэмших, өмчлөх, ашиглах, хилийн цэстэй холбоотой асуудлаар нийт 2532 маргаан гарсан байх бөгөөд үүнээс шийдвэрлэсэн 1874, шийдвэрлээгүй 658 хэрэг байна.


Аймаг, нийслэлийн газрын зөрчил маргааны тоог нэгтгэж үзэхэд нийт 3572 газрын зөрчил, маргаан гарснаас 2217 шийдвэрлэн, 1355 хэргийг шийдвэрлээгүй байна.

Газрын зөрчил, маргааныг шийдвэрлээгүй шалтгаан иргэний болон захиргааны шүүх байгууллагад хянагдаж, шүүхийн шийдвэр гараагүй, дур мэдэн хашаа барьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хугацаатай мэдэгдэл өгсөн боловч чөлөөлөөгүй зэрэг шалтгааны улмаас шийдвэрлэгдээгүй байна.



Зураг 1.5.1. Газрын зөрчил, маргаан шийдвэрлэсэн, шийдвэрлэгдээгүй байдал

Улсын хэмжээнд гарсан 2023 оны газрын зөрчил, маргааны тоог 2022 оны газрын зөрчил, маргааны тоотой харьцуулахад эзэмших эрхтэй холбоотой үүссэн маргаан 4601-ээр, хилийн цэсийн асуудлаар үүссэн маргаан 193-аар, газар ашиглах эрхтэй холбоотой үүссэн маргаан 75-аар тус тус буурч, газар өмчлөх эрхтэй холбоотой үүссэн маргаан 21-ээр өссөн дүнтэй байна.



Зураг 1.5.2. 2022, 2023 оны газрын зөрчил, маргааны харьцуулсан үзүүлэлт

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт 2023 оны байдлаар Захиргааны болон Иргэний хэргийн анхан шатны шүүх, байгууллагаас нийт 53 захирамж, тогтоол ирсний дагуу тус газрын даргын тушаалаар шинжээчийн дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг тухай бүр байгуулан шинжээчийн дүгнэлтийг холбогдох газарт хүргүүлсэн байна. Үүнд:

- Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс-28
- Иргэний хэргийн анхан шатны шүүхээс-15
- Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн-10

2023 онд Иргэний болон Захиргааны хэргийн анхан шатны шүүх, иргэн, аж ахуй нэгж, байгууллагад 321 удаагийн нотлох баримт, лавлагаа гарган хүргүүлсэн байна.

2023 оны шинжээчийн дүгнэлт буюу нотлох баримт хүргүүлсэн байдлыг өмнөх 2022 онтой харьцуулан үзэхэд нотлох баримт гаргуулах өргөдөл, хүсэлт 17 хувиар, шинжээчийн дүгнэлт гаргах ажил 37 хувиар тус тус буурсан дүнтэй байна.

Дээрх тайлан, мэдээнээс дүгнэхэд газрын маргаан гарч буй шалтгааныг ангилж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас шалтгаалсан;

Газар эзэмших гэрээний нөхцөл зөрчсөн:

- Газар, эзэмших, ашиглах гэрээ дүгнүүлээгүй;
- Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулаагүй;
- Захирамжаар олгогдсон газрын хэмжээг дур мэдэн нэмэгдүүлсэн;
- Газар дээрээ хил заагаа тэмдэгжүүлж, хашаа бариагүй;
- Холбогдох хууль тогтоомж болон норм дүрэм зөрчсөн;
- Нийтийн эзэмшлийн зам талбайг зөвшөөрөлгүй эзэмших, ашиглах /хашаа хайс, объект барих/;

- Эрх зүйн харилцаа үүссэн газрынхаа хил, зааг дотор барилга байгууламжийг барьдаггүй, газар доогуур бусдын эзэмшлийн газарт авто гарааш барих;
- Инженерийн шугам сүлжээ, өндөр хүчдэл бүхий газрын хамгаалалтын зурвас газарт буух /хашаа хайс барих/;

2. Төрийн байгууллага, эрх бүхий албан тушаалтнаас шалтгаалсан;

Эрх бүхий албан тушаалтнаас:

- Эзэмшиж, өмчилж буй газар дээр давхардуулан газар олголт хийх;
- Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт газар олголт хийх;
- Газар олголтыг хийхдээ хээрийн судалгааг хийхгүй байх;
- Газар эзэмших өмчлөх эрхийг шилжүүлэхдээ санаатай болон санамсаргүйгээр нэгж талбарын мэдээллийг судлахгүйгээр эрхийг шилжүүлэн маргаан гаргах;

## 1.6. ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХ БОЛОН ӨМЧИЙН ГАЗРАА БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД БАРЬЦААЛСАН БАЙДЛЫН ТАЙЛАН

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “Газар эзэмших эрхийн гэрчилгээг хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр бусдад шилжүүлж, барьцаалж болно. Эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, барьцаалах үйл ажиллагаа нь зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд явагдана” гэж заасны дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага улсын бүртгэлд бүртгүүлдэг.


Мөн “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1.3.12-д “Эрхийн гэрчилгээ барьцаалах” хүсэлтийн дагуу Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн ерөнхий газраас Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системээр барьцааны бүртгэлийг хийж байгаа бөгөөд 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, сумын Газрын даамлууд газар ашиглуулсан, барьцаалсан бүртгэлийг бүртгэж жилийн эцсээр нэгтгэн тайлан гаргаж байна.

Тухайн бүртгэлээс харахад 2023 онд улсын хэмжээнд 14296 газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагад, Улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан судалгаагаар 34828 өмчийн газраа банк, санхүүгийн байгууллагад тус тус барьцаалсан байх ба нийт 49124 нэгж талбар /газар эзэмших эрх, өмчийн газар/ буюу Монгол Улсын нийт нэгж талбарын 3.8 хувийг банк, санхүүгийн байгууллага болон иргэн, хуулийн этгээдэд барьцаалсныг бүртгэсэн байна.

*Хүснэгт 1.6.1. Газар эзэмших эрх болон өмчийн газраа барьцаалсан байдал*

№	Аймаг, нийслэл	Барьцаалсан нэгж талбарын тоо	Үүнээс	
			Эзэмших	Өмчлөх
1	Архангай	813	224	589
2	Баян-Өлгий	1699	553	1146
3	Баянхонгор	1572	210	1362

4	Булган	796	357	439
5	Говь-Алтай	877	320	557
6	Говьсүмбэр	309	48	261
7	Дархан-Уул	1715	382	1333
8	Дорнод	898	182	716
9	Дорноговь	1097	727	370
10	Дундговь	401	100	301
11	Завхан	828	236	592
12	Орхон	2537	309	2228
13	Өвөрхангай	2198	422	1776
14	Өмнөговь	1630	184	1446
15	Увс	1755	536	1219
16	Сүхбаатар	807	139	668
17	Сэлэнгэ	3467	1711	1756
18	Төв	2498	879	1619
19	Ховд	2339	1041	1298
20	Хөвсгөл	2730	937	1793
21	Хэнтий	1150	218	932
22	Улаанбаатар	17008	4581	12427
<b>ДҮН</b>		<b>49124</b>	<b>14296</b>	<b>34828</b>



Зураг 1.6.1. Газар эзэмших эрхийн барьцаа бүртгүүлсэн байдал


Тайлант онд бүртгүүлсэн газар эзэмших эрхээ болон өмчийн газраа барьцаалсан байдлаас харахад нийт барьцаанд байгаа газрын 50 хувь нь гэр бүлийн хэрэгцээний газар, 25 хувь нь хөдөө аж ахуйн зориулалттай газар, 23 хувь нь үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай газар, 1 хувь нь бусад зориулалтын газар тус тус эзэлж байна. Дээрх зориулалтуудаар барьцаалсан байдлыг зураг 1.6.2-д үзүүлэв.





Зураг 1.6.2. Барьцаалсан газрын зориулалт ба төрөл

Мөн 2023 онд газар эзэмших эрхээ барьцаалсан байдлаас харахад 58.2 хувийг банканд, үлдсэн 41.8 хувийг банк бус санхүүгийн байгууллага, хоршоо болон иргэн, аж ахуй нэгж, байгууллагад барьцаалсан байна. Үүнээс хамгийн их хувь буюу 55.8 хувийг Хаан банканд, 12.6 хувийг Төрийн банканд, 12.5 хувийг Хас банканд, 7.1 хувийг Голомт банканд, 5.3 хувийг Худалдаа хөгжлийн банканд, 6.6 хувийг бусад банканд барьцаалсан байна /Зураг 1.6.3/.



Зураг 1.6.3. Газар эзэмших эрхийг банканд барьцаалсан байдал.

Газар эзэмших эрх болон өмчийн газрыг банк, санхүүгийн байгууллагад дундажаар 3.6 жилийн хугацаатайгаар барьцаалсан байна.

### 1.7. ГАЗРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Газрын үнэд байршил, зориулалт, орчин нөхцөл, инженерийн шугам сүлжээ, бичиг баримтын бүрэн эсэх зэрэг хүчин зүйлүүд нөлөөлөхөөс гадна барилга барих тусгай зөвшөөрөл буюу техникийн нөхцөл, газар зохион байгуулалтын болон хотын

хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, Засгийн газрын төрийн бодлого шийдвэрээс ихээхэн хамаардаг.

Мөн газар, үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх нь инфляцийн эсрэг сайн хамгаалалт болдог тул хөрөнгө оруулагчид энэ төрлийн хөрөнгө оруулалтыг сонирхдог бөгөөд газар болон үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн талаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлуудыг судлан зах зээлийн бүтэц, оролцогч талуудын оролцоо, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлүүдийг судалж дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай байдаг.

Иймд газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг бүрдүүлж, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан байгуулах зорилгоор Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд тус системийг ашиглан нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргүүдийн Газар зохион байгуулалтын алба, сумдын газрын даамлууд үйл ажиллагаандаа ашиглаж, газрын зах зээлийн үнийн мэдээг цуглуулж байна.

Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг гэр бүлийн хэрэгцээний зориулалттай /ГХ/, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай /ХАА/, худалдаа үйлчилгээний зориулалттай /ХҮ/, хөдөө аж ахуйн газраас бусад үйлдвэрлэлийн зориулалттай /Ү/ гэсэн 4 төрлөөр цуглуулж байгаа бөгөөд газрын эрхээ шилжүүлж байгаа худалдагчаас, шилжүүлж авч байгаа худалдан авагчаас, түрээслэгч, түрээсүүлэгч болон бусад эх сурвалжаас бүрдүүлж байна.


2023 оны жилийн эцсийн байдлаар Газрын биржийн цахим системд нийт 8456 газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээ бүртгэсэн. Бүртгэгдсэн газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээнээс гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 6652, худалдаа үйлчилгээний зориулалттай 560, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай 1121, хөдөө аж ахуйн газраас бусад үйлдвэрлэлийн зориулалттай 122 үнийн мэдээ тус тус эзэлж байна.

Хүснэгт 1.7.1. Газрын зах зээлийн үнийн мэдээ цуглуулсан байдал

№	Аймаг/ нийслэл	Нийт үнийн мэдээ	Үүнээс							
			Гэр бүлийн хэрэгцээний газар	Үүнээс		Худалдаа үйлчилгээний газар	Үүнээс		Хөдөө аж ахуйн газар	Үйлдвэрийн газар
				Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй		Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй		
1	Нийслэл	933	770	-	770	51	1	50	34	78
2	Архангай	215	145	12	133	36	8	28	34	-
3	Баян-Өлгий	221	189	11	178	6	4	2	23	2
4	Баянхонгор	648	435	97	338	62	7	55	143	8
5	Булган	285	176	64	112	30	16	14	76	3
6	Говь-Алтай	166	76	2	74	27	2	25	61	2
7	Говьсүмбэр	65	52	2	50	10	2	8	2	1
8	Дархан-Уул	385	284	52	232	48	33	15	47	6

9	Дорноговь	256	237	75	160	8	2	6	8	3
10	Дорнод	162	162	-	162	-	-	-	-	-
11	Дундговь	254	207	1	206	24	8	16	23	-
12	Завхан	54	37	12	25	9	3	6	8	-
13	Орхон	836	834	38	-	2	-	2	-	-
14	Өвөрхангай	473	373	38	335	38	6	32	59	3
15	Өмнөговь	518	469	-	469	21	-	21	24	4
16	Сэлэнгэ	559	326	65	261	41	41	-	192	-
17	Сүхбаатар	140	125	32	93	9	6	3	6	-
18	Төв	1638	1258	192	1066	67	8	59	308	5
19	Увс	46	33	1	32	1	1	-	12	-
20	Ховд	55	8	-	8	17	-	17	30	-
21	Хэнтий	158	126	6	120	15	3	12	12	5
22	Хөвсгөл	389	330	96	234	38	8	30	19	2
<b>Нийт дүн</b>		<b>8456</b>	<b>6652</b>	<b>796</b>	<b>5058</b>	<b>560</b>	<b>159</b>	<b>401</b>	<b>1121</b>	<b>122</b>

Тайланд хугацаанд цуглуулсан газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээний 78.7 хувийг гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын үнийн мэдээ, 6.7 хувийг худалдаа үйлчилгээний зориулалттай газрын үнийн мэдээ, 13.2 хувийг хөдөө аж ахуйн зориулалттай газрын үнийн мэдээ, 1.4 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай газрын үнийн мэдээ эзэлж байгаа юм.



Зураг 1.7.1. Газрын зах зээлийн үнийн мэдээний эзлэх хувь.

Нийт цуглуулсан үнийн мэдээний 73.6 хувь нь шууд худалдагсан үнэ, 19.1 хувь нь дуудлага худалдаагаар худалдсан үнэ, 1.2 хувь нь үнэлэгдсэн болон түрээсийн үнэ, 6.1 хувийг худалдахаар санал болгож буй үнэ тус тус эзэлж байна.




Зураг 1.7.2. Газрын зах зээлийн үнийн мэдээний төрөл.

Хүснэгт 1.7.2. 1 метр.кв газрын зах зээлийн дундаж үнэ /төг-өөр/.

Аймаг/ нийслэл	1 м.кв газрын дундаж үнэ							
	Гэр бүлийн хэрэгцээний газар	Үүнээс		Худалдаа үйлчилгээний газар	Үүнээс		Хөдөө аж ахуйн газар	Үйлдвэрийн газар
		Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй		Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй		
Нийслэл	72,765.5	55,720	34,091	53,712	-	153,712	17,882	97,930
Архангай	39,178.0	33,205	11,946	44,478	79,131	32,927	1,684	-
Баян-Өлгий	29,543.5	26,151	6,785	13,888	8,000	19,777	5,575	10,000
Баянхонгор	18,353	12,268	12,170	21,320	13,472	22,173	2,244	7,321
Булган	17,992.5	14,182	7,621	41,895	31,490	54,700	2,451	4,233
Говь-Алтай	21,668	16,252	10,832	62,106	20,216	54,074	2,937	-
Говьсүмбэр	-	-	6,738	68,339	-	58,339	7,942	2,000
Дархан-Уул	36,933	28,847	16,172	151,726	76,676	21,828	794	7,757
Дорноговь	37,076	32,717	8,718	176,840	80,200	44,368	1,265	12,940
Дорнод	-	-	4,883	-	-	-	-	-
Дундговь	34,250.5	28,076	12,349	40,501	52,000	16,680	888	-
Завхан	6,515	4,537	3,956	6,300	11,820	3,540	125	-
Орхон	14,894.5	10,648	8,493	66,666	92,000	66,000	-	-
Өвөрхангай	17,370	13,605	7,530	94,610	57,220	23,402	1,936	12,390
Өмнөговь	-	-	14,985	13,428	-	13,428	4,019	2,174
Сэлэнгэ	11,558.5	7,666	7,785	171,542	55,260	55,000	518	3,620
Сүхбаатар	42,464	30,155	24,618	139,918	50,779	38,196	2,493	-
Төв	5,969.5	3,994	3,951	18,966	3,380	21,319	1,831	3,380
Увс	11,936.5	7,552	8,769	22,471	22,471	-	2,034	-
Ховд	-	-	6,834	474,067	-	4,067	443	-
Хэнтий	14,976	11,404	7,144	23,441	19,365	26,411	-	6,349
Хөвсгөл	12,450	9,922	5,056	5,449	6,984	5,120	327	1,957
<b>Дундаж</b>	<b>24,771.8</b>	<b>17,128.3</b>	<b>10,519.4</b>	<b>81,507.8</b>	<b>40,027.3</b>	<b>36,753.1</b>	<b>3,020.4</b>	<b>13234.7</b>

Гэр бүлийн хэрэгцээний газар:

Газрын биржийн цахим системд бүртгэгдсэн гэр бүлийн хэрэгцээний газрын 6652 үнийн мэдээ бүртгэгдсэн бөгөөд уг мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд газрын үнэ нь байршил, орон нутгийн эдийн засаг, нийгмийн байдлаас хамаарч харилцан адилгүй байгаа тул газрын үнийг улсын хэмжээнд дундажлах боломжгүй байна. Иймд аймаг тус бүрээр нь газрын дундаж үнийг тооцож гаргасан.




Зураг 1.7.3. Гэр бүлийн хэрэгцээний 1 метр квадрат газрын дундаж үнэ

Тайлант хугацаанд үл хөдлөх хөрөнгөгүй болон хөрөнгөтэй гэр бүлийн хэрэгцээний газрын дундаж үнэ нийслэл хотод хамгийн өндөр бөгөөд байршлаасаа хамаарч харилцан адилгүй байна.

Мөн аймгуудын хувьд хөрөнгө оруулалт хийгдсэн гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ Архангай, Сүхбаатар, Дундговь, Дорноговь, Баян-Өлгий, Дархан-Уул аймагт харьцангуй өндөр буюу 26,151-33,205 төгрөг байна. Харин Дорнод, Говьсүмбэр, Өмнөговь, Ховд аймгуудад үл хөдлөх хөрөнгө бүхий газрын зах зээлийн үний мэдээ бүртгэгдээгүй байна.

Худалдаа үйлчилгээний зориулалттай газар:

Тайлант хугацаанд улсын хэмжээнд худалдаа үйлчилгээний зориулалттай газрын зах зээлийн үнийн 560 мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна.




**Зураг 1.7.4. Худалдаа, үйлчилгээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ**

Худалдаа, үйлчилгээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ Улаанбаатар хотын хувьд 153,712.0 төгрөг байсан бол Орхон, Дархан-Уул, Дундговь, Дорноговь, Архангай зэрэг аймгуудын худалдаа, үйлчилгээний зориулалттай газрын үнэ харьцангуй өндөр гарсан байна.

ХАА-н зориулалттай газар

Улсын хэмжээнд хөдөө аж ахуйн зориулалттай /төмс, хүнсний ногоо тариалан, жимс, жимсгэний усалгаагүй тариалан, үр тарианы усалгаагүй тариалан, өвөлжөө, хаваржааны гэх мэт/ газрын зах зээлийн үнийн 1121 мэдээ цуглуулсан байна.



Зураг 1.7.5. Хөдөө аж ахуйн 1 метр квадрат газрын газрын дундаж үнэ


Тайлант хугацаанд хөдөө аж ахуйн зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ Улаанбаатар хотод 17,882.0 төгрөг байсан бол Говьсүмбэр, Баян-Өлгий, Өмнөговь зэрэг аймгуудад харьцангуй өндөр 4,019.0-7,942.0 төгрөг байна. Харин Орхон, Хэнтий, Дорнод аймгуудад хөдөө аж ахуйн газрын үнэ бүртгэгдээгүй байна.

Мөн Хөвсгөл, Ховд, Сэлэнгэ, Завхан, Дундговь, Дархан-Уул аймгуудад харьцангуй бага үнэтэй бүртгэгдсэн байна.

Үйлдвэрийн газар

Тайлант онд улсын хэмжээнд үйлдвэрийн зориулалттай газрын зах зээлийн үнийн 122 мэдээ цуглуулсан үүнээс хамгийн өндөр буюу Улаанбаатар хотын үйлдвэрийн зориулалттай 1 метр квадрат газрын дундаж 97,930.0 төгрөг, хамгийн

бага нь Хөвсгөл аймагт 1,957.0 төгрөг байна. Харин Хэнтий, Төв, Сэлэнгэ, Өмнөговь, Өвөрхангай, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Булган, Баянхонгор, Баян-Өлгий аймгуудын хувь 2,000.0-12,940.0 төгрөгийн хооронд байна. Мөн Ховд, Увс, Сүхбаатар, Орхон, Завхан, Дундговь, Дорнод, Говь-Алтай, Архангай аймгуудад үйлдвэрлэлийн зориулалттай газрын үнэ бүртгэгдээгүй байна.



Зураг 1.7.6. Үйлдвэр үйлчилгээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ.

## 1.8. ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ДУУДЛАГА ХУДАЛДАА, ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭ, ТАЙЛАН

Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа, газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг дараах тогтоол, журам, аргачлалуудын дагуу улсын хэмжээнд зохион байгуулан ажиллав. Үүнд:

- Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, 2 дугаар



хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”;

- Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал”;
- Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 182 дугаар тогтоол;
- Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 208 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал”.


Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа

Улсын хэмжээнд 2023 онд 2,957 удаа газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулснаас 1,246 дуудлага худалдаа хүчинтэй буюу 2,938.2 га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлжээ. Энэ нь өмнөх оныхтой харьцуулж үзвэл газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан тоо 1,268-аар, эзэмшүүлсэн газрын хэмжээ 4801.3 га-гаар, улсын төсөвт оруулсан орлогын хэмжээ 19 тэрбум төгрөгөөр буурсан байдалтай байна.

*Хүснэгт 1.8.1. 2022-2023 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан байдал.*

№	Аймаг, нийслэл	Дуудлага худалдаа зохион байгуулсан тоо		Талбай /га/		Төсөвт орсон орлого /сая.төг/	
		2022 он	2023 он	2022 он	2023 он	2022 он	2023 он
1.	Архангай	194	195	1,355.31	182.92	1,281.8	731.8
2.	Баян-Өлгий	160	81	126.73	30.06	319.9	262.6
3.	Баянхонгор	112	134	185.75	983.28	267.6	185.8
4.	Булган	225	154	394.09	309.33	828.7	1,635.5
5.	Говь-Алтай	83	78	54.82	139.77	171.6	60.2
6.	Говьсүмбэр	31	20	76.24	58.66	570.6	333.6
7.	Дархан-Уул	13	36	4.83	40.05	-	1,547.0
8.	Дорноговь	264	190	1,892.56	860.23	25,444.0	4,151.5
9.	Дорнод	221	143	261.83	453.65	562.5	2,991.7
10.	Дундговь	82	53	51.40	56.18	146.5	171.9
11.	Завхан	500	200	4,913.48	2,485.96	501.5	204.0
12.	Орхон	26	15	105.29	63.19	106.8	586.4
13.	Өвөрхангай	127	113	1,157.97	175.93	308.1	632.2
14.	Өмнөговь	132	74	615.53	136.03	1,853.8	1,700.2
15.	Сүхбаатар	105	84	335.19	126.93	766.4	942.6


16.	Сэлэнгэ	538	419	1,262.98	1,242.16	1,393.2	1,351.1
17.	Төв	305	267	1,019.40	1,166.13	2,633.3	3,334.9
18.	Увс	94	74	26.35	30.06	743.8	250.4
19.	Ховд	345	190	168.80	283.50	328.1	928.9
20.	Хөвсгөл	173	199	83.19	447.93	318.9	671.3
21.	Хэнтий	272	172	530.91	742.48	1,681.0	309.9
22.	Нийслэл	223	66	288.42	95.32	2,738.6	928.9
<b>ДҮН</b>		<b>4,225</b>	<b>2,957</b>	<b>14,911.06</b>	<b>10,109.74</b>	<b>42,966.6</b>	<b>23,747.3</b>



*Зураг 1.8.1. 2023 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан байдал.*

2023 онд нийслэл, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дорноговь, Дорнод, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хэнтий, Хөвсгөл, аймгууд хамгийн олон буюу 100-аас дээш газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, бусад аймгууд 13-94-ийн хооронд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулсан байна.


2022 он, 2023 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа явуулсан тоог аймаг, нийслэлээр харьцуулан дараах зурагт үзүүлэв /Зураг 1.8.2/.



Зураг 1.8.2. 2022 он, 2023 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа явуулсан тоо

2023 онд нийт 2,957 удаагийн дуудлага худалдааг зохион байгуулснаас 1,711 удаагийн буюу 57.8 хувь нь хүчингүй болсон ба үүнээс 1,241 удаагийн буюу 41.9 хувь нь оролцогчгүйн улмаас хүчингүй болж, 367 удаагийн буюу нийт зохион байгуулсан дуудлага худалдааны 12.4 хувь нь дуудлага худалдааны үнийг “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-д заасан хугацаанд төлөөгүй, 103 удаагийн буюу 3.5 хувь цуцлагдсан байна.


Мөн дуудлага худалдаанд оролцогчгүй тохиолдол 41 хувь болж, 17 хувиар буурсан, 1 оролцогч оролцсон тохиолдол 11 хувь болж 0.4 хувиар буурсан, 2 оролцогч оролцсон тохиолдол 24 хувь болж 2.7 хувиар өссөн, 2-оос дээш оролцогч оролцсон тохиолдол 24 хувь болж 7.5 хувиар өссөн байна /Зураг 1.8.3/.



Зураг 1.8.3. Дуудлага худалдааны оролцогчийн эзлэх хувь


“Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-д заасны дагуу цахим болон танхимын хэлбэрээр дуудлага худалдааг зохион байгуулах бөгөөд 2023 онд Улаанбаатар, Архангай, Баян-Өлгий, Говь-

Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Увс, Ховд, Хөвсгөл аймгууд дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна. Харин бусад аймгууд цахим болон танхимын хэлбэрээр дуудлага худалдаа зохион байгуулсан байна / Зураг 1.8.4/.



Зураг 1.8.4. 2023 онд цахим хэлбэрээр зохион байгуулсан дуудлага худалдаа

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын хэмжээнд 2023 онд нийт **23 тэрбум 747 сая 307 мянган** төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс Дорноговь аймаг 17 хувь буюу 4 тэрбум 151 сая төгрөг, Төв аймаг 14 хувь буюу 3 тэрбум 334 сая төгрөг, Дорнод аймаг 13 хувь буюу 2 тэрбум 991 сая төгрөг, Өмнөговь аймаг 7 хувь буюу 1 тэрбум 700 сая төгрөг, Булган аймаг 7 хувь буюу 1 тэрбум 635 сая төгрөг, Дархан-Уул аймаг 7 хувь буюу 1 тэрбум 547 сая төгрөгийг тус тус эзэлж байна.



Зураг 1.8.5. 2022 он, 2023 онд улсын хэмжээнд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын төсөвт орсон орлого /тэрбум төгрөг/

2022 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааны орлогоос орон нутгийн төсөвт **42.9** тэрбум төгрөг төвлөрүүлж байсан бол уг дүн 2023 онд 19.2 тэрбум төгрөгөөр буурч **23.7** тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна / Зураг 1.8.6/.



Зураг 1.8.6. 2010-2023 онд улсын хэмжээнд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын төсөвт орсон орлого /тэрбум төгрөг/

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааг танхимаар зохион байгуулж байх үед жилд дунджаар 4 тэрбум төгрөг улсын төсөвт ордог байсан бол Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг хэрэглээнд нэвтрүүлж, дуудлага худалдааг цахимаар зохион байгуулдаг болсноор дуудлага худалдаанаас улсын төсөвт орох орлогын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд 2023 оны байдлаар дуудлага худалдааны орлого 23.7 тэрбум төгрөг буюу 5.9 дахин өссөн байдалтай байна.

Газар эзэмшүүлэх эрхийн төсөл сонгон шалгаруулалт

Улсын хэмжээнд 2023 онд Архангай, Баян-Өлгий, Булган, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс аймагт 141 газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулснаас нийт зохион байгуулсан төсөл сонгон шалгаруулалтаас 85 нь хүчинтэй болж, 166'574.1 га газрыг эзэмшүүлжээ /Хүснэгт 1.8.2/.


Бусад аймаг, нийслэлд газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй.

Хүснэгт 1.8.2. 2023 оны газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтын мэдээ

№	Аймаг, нийслэл	Төсөл сонгон шалгаруулалт явуулсан тоо		Төсөл сонгон шалгаруулалт явуулсан талбайн хэмжээ /га/	
		2022 он	2023 он	2022 он	2023 он
1.	Архангай	25	14	32.2	12.26
2.	Баян-Өлгий	-	1		0.25
3.	Булган	-	3		64.63
4.	Дорноговь	1	4	-	97.13
5.	Дундговь	9	10	355'519.2	145048.39
6.	Өвөрхангай	33	3	-	
7.	Өмнөговь	15	67	88.6	20604.4
8.	Сэлэнгэ		4		29.06
9.	Төв	54	34	788.4	703.38

10.	Увс	-	1	-	0.31
11.	Ховд	1		0.5	
12.	Хэнтий	1		11.2	
<b>ДҮН</b>		<b>139</b>	<b>141</b>	<b>356'440.1</b>	<b>166574.17</b>

2023 онд 141 газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулснаас 58 нь буюу 41.1 хувь нь гэрээ байгуулсан, 38 нь буюу 26.9 хувь нь төсөл ирээгүйн улмаас хүчингүй, 12 нь буюу 8.5 хувь нь шаардлага хангаагүй, 6 нь буюу 4.2 хувь нь цуцлагдсан байна. /Зураг 1.8.7/.




Зураг 1.8.7. Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтын оролцогчийн эзлэх хувь

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлсэн хугацааны хувьд авч үзвэл ихэвчлэн 15 жилээр эзэмшүүлсэн байна.

### 1.9.СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНД АШИГЛУУЛЖ БУЙ ГАЗРЫН ТАЙЛАН

Улсын хэмжээнд нийт Сууц өмчлөгчдийн 1270 холбоо үйл ажиллагаа явуулж байгаагаас нийслэлд 1095, орон нутагт 1 бүртгэгдсэн байна. 2009 оноос хойшхи СӨХ-ны бүртгэгдсэн байдлыг дараах зурагт харуулав /Зураг 1.9.1/.



Зураг 1.9.1. СӨХ-ны тоо

Хүснэгт 1.9.1. СӨХ-ны орчны газрын баталгаажилтын явц /Улсын хэмжээнд/

Д/Д	Аймаг	Нийт СӨХ-ны тоо	Үүнээс								
			Тооллогонд хамрагдсан СӨХ-ны тоо	Газар ашиглахаар хүсэлт гаргасан СӨХ-ны тоо	Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажсан	Захирамжаар баталгаажигдсан СӨХ-оос газар ашиглах эрхийн гэрээ байгуулсан	Нийт СӨХ-ны ашиглаж байгаа талбайн хэмжээ /м2/	Маргаантай болон судалж байгаа	Захирамж гарахаар хүлээгдэж байгаа	Ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаа СӨХ-ны тоо	Ерөнхий төлөвлөгөө хийгдсэн СӨХ-ны тоо
1	Архангай	2	-	-	2	1	48600.0	0	11	0	0
2	Баян-Өлгий	2	1	1	2		40610	1			
3	Булган	2	-	-	2	1	32897.9				
4	Говь-Алтай	5	-	-	5	5	51000.0	0	0	0	0
5	Говьсүмбэр	2	-	-	2	2	123334.0	-	-	-	-
6	Дархан-Уул	50	39	6	42	50	618785.0	3	1	4	37
7	Дорнод	24	24		8	8	239134.0	-	-	-	-
8	Дорноговь	23	23	3	12	23	255671.4	-	-	2	-
9	Дундговь	2		1	1		12370.0				
10	Орхон	27	6	-	21	21	824500.0	-	-	-	-
11	Өвөрхангай	7	0	0	0	7	40050.0	-	-	-	-
12	Өмнөговь	3	2	2	2	3	14810.7	-	-	-	-
13	Сүхбаатар	1	1	0	1	1	3500.0	-	-	-	-
14	Сэлэнгэ	20	-	-	19	20	208205.0	-	-	-	-
15	Хөвсгөл	4	-	3	3	3	59484.5				
16	Хэнтий	1	-	-	1	-	700	-	-	-	-
17	Нийслэл	1095	482	40	1095	794	1457566.0	-	15	-	-

Нийт	1270	578	55	1216	939	4031219	4	27	6	37
------	------	-----	----	------	-----	---------	---	----	---	----

Тайлант оны байдлаар Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт 1270 СӨХ-ны 1216 нь орчны газраа ашиглах эрхээ аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулж, 403.1 га газрыг ашиглуулахаар гэрээ байгуулсан байна.

### 1.10. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

#### Нийслэл, сум, дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

Улсын хэмжээнд нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газрын нэгдмэл сангийн ангиллын газарт нийтдээ **105575** байршилд **5641.2** мянган га газар төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар нийт **57087** байршилд **4992.1** мянган га газрыг өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг дараах аймгууд хангалттай сайн хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн цахим системээс 2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг үзэхэд Говьсүмбэр аймаг 91.56 хувь, Архангай аймаг 77.53 хувь, Булган аймаг 73.75 хувь, Завхан аймаг 73.10 хувь, Увс аймаг 72.21 хувь, Өвөрхангай аймаг 71.46 хувь, Хэнтий аймаг 68.81 хувь, Орхон аймаг 68.24 хувь, Хөвсгөл аймаг 67.56 хувь, Говь-Алтай аймаг 67.12 хувь, Дорноговь аймаг 66.51 хувь, Баян-Өлгий аймаг 61.71 хувь, Өмнөговь аймаг 58.47 хувь, Сэлэнгэ аймаг 57.87 хувь, Төв аймаг 54.98 хувь, Баянхонгор аймаг 52.44 хувь, Дундговь аймаг 51.50 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Харин 50 хувиас доош хэрэгжилттэй Дархан-Уул аймаг 48.85 хувь, Улаанбаатар 47.12 хувь, Дорнод аймаг 40.87 хувь, Сүхбаатар аймаг 35.84 хувь, Ховд аймаг 34.85 хувьтай хэрэгжүүлсэн байна.


#### Хүснэгт 1.10.1. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал

Д/д	Аймаг, нийслэл	2023 онд төлөвлөсөн		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь
		Нэгж талбарын тоо	Нийт талбайн хэмжээ /га/	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	
1	Архангай	1825	455.88	1415	236.39	77.5
2	Баян-Өлгий	2267	96043.45	1399	95679.67	61.7
3	Баянхонгор	2164	1563221.59	1135	1547012.83	52.4
4	Булган	3746	121825.02	2763	101540.28	73.8
5	Говь-Алтай	1813	186496.56	1217	185920.85	67.1
6	Говьсүмбэр	166	11104.13	152	11101.06	91.6
7	Дархан-Уул	1883	1535.11	920	386.14	48.9
8	Дорноговь	1568	1535576.52	1043	1499401.7	66.5



**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

9	Дорнод	2750	402385.3	1124	64973.39	40.9
10	Дундговь	1295	490182.77	667	487255.35	51.5
11	Завхан	1732	347969.92	1267	343412.68	73.1
12	Орхон	1713	742.01	1169	452.21	68.2
13	Өвөрхангай	2306	368561.78	1648	230221.3	71.5
14	Өмнөговь	1452	8810.9	849	3307.2	58.5
15	Сүхбаатар	2173	7234.82	779	1663.61	35.8
16	Сэлэнгэ	6193	10240.3	3584	5481.32	57.9
17	Төв	12272	199005.66	6748	171,765.32	55.0
18	Увс	2642	96590.05	1908	90329.58	72.2
19	Ховд	3067	4105.23	1069	2381	34.9
20	Хөвсгөл	2821	24078.62	1906	20111.2	67.6
21	Хэнтий	4104	155115.56	2824	126,530.23	68.8
22	Улаанбаатар	45623	9,945.01	21501	2,505.22	47.1
<b>Нийт</b>		<b>105575</b>	<b>5641226.19</b>	<b>57087</b>	<b>4991668.53</b>	<b>54.1</b>



*Зураг 1.10.1. Арга хэмжээний төрлөөр тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт*

*Хүснэгт 1.10.2. Тухайн жилийн төлөвлөгөөг арга хэмжээний төрлөөр харуулсан байдал*


Д/д	Арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн нэгж талбарын тоо	Хэрэгжсэн нэгж талбарын тоо	Хэрэгжилтийн хувь
1	Төсөл сонгон шалгаруулалт	207	81	39.13
2	Өргөдлийн дагуу олгох	99600	54015	54.23
3	Нөхөн сэргээх, хамгаалах	1256	857	68.23
4	Нийтийн эдэлбэр газрын төлөвлөлт	1537	747	48.6
5	Дуудлага худалдаагаар олгох	2805	1295	46.16
6	Газар чөлөөлөх	170	92	54.11
<b>Нийт</b>		<b>105575</b>	<b>57087</b>	<b>54.07</b>

*Хүснэгт 1.10.3. Сүүлийн 3 жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хувиар харьцуулан байдал*

Д/д	Аймаг, нийслэлийн нэр	2021 он	2022 он	2023 он
1	Архангай	60.13	37.67	77.5
2	Баян-Өлгий	35.74	44.22	61.7
3	Баянхонгор	12.14	28.09	52.4
4	Булган	68.28	71.08	73.8
5	Говь-Алтай	59.16	65.65	67.1

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

6	Говьсүмбэр	78.38	90.82	91.6
7	Дархан-Уул	47.74	67.2	48.9
8	Дорноговь	48.32	69.31	66.5
9	Дорнод	50.04	26.23	40.9
10	Дундговь	58.46	67.07	51.5
11	Завхан	52.62	68.66	73.1
12	Орхон	49.47	44.44	68.2
13	Өвөрхангай	20.99	18.13	71.5
14	Өмнөговь	16.29	52.41	58.5
15	Сүхбаатар	30.74	33.83	35.8
16	Сэлэнгэ	28.45	66.84	57.9
17	Төв	20.54	42.85	55
18	Увс	42.05	58.03	72.2
19	Ховд	58.78	46.24	34.9
20	Хөвсгөл	60.79	69.76	67.6
21	Хэнтий	80.42	80.19	68.8
22	Улаанбаатар	61.53	48.7	47.1
<b>Нийт</b>		<b>42.41</b>	<b>54.42</b>	<b>54.1</b>



*Зураг 1.10.2. Сүүлийн 3 жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зургаар харуулсан байдал.*

Хот, тосгон, бусад суурины газрын 2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт


Улсын хэмжээнд нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөнд хот, тосгон, бусад суурины ангиллын газарт нийт 88198 байршилд 69.43 мянган га газрыг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар нийт 46974 байршилд 42.28 мянган га газрыг өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулж, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 1.10.4. Хот, тосгон, бусад суурины газрын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг аймаг, нийслэлээр харуулсан байдал.*


Д/д	Аймаг, нийслэл	2023 онд төлөвлөсөн		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь
		Нийт нэгж талбар	Нийт талбайн хэмжээ /га/	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	
1	065: Архангай	951	330.23	702	179.15	73.81
2	064: Баянхонгор	1597	12,864.49	805	8,675.50	50.4
3	083: Баян-Өлгий	1738	144.48	1202	95.97	69.15
4	063: Булган	3144	2,859.02	2368	2,721.28	75.31
5	082: Говь-Алтай	1079	225.01	587	57.77	54.4
6	042: Говьсүмбэр	135	297.23	121	294.17	89.6
7	045: Дархан-Уул	1459	1033.71	669	153.54	45.85
8	044: Дорноговь	1338	1672.15	894	1436.64	66.81
9	021: Дорнод	1103	4418.15	447	632.21	40.52
10	048: Дундговь	973	5057.73	419	3807.7	43.06
11	081: Завхан	975	195.32	800	125.39	82.05
12	062: Өвөрхангай	1330	4121.87	1016	3810.93	76.39
13	046: Өмнөговь	1096	2317.85	619	1890.58	56.47
14	061: Орхон	1611	635.2	1089	394.83	67.59
15	022: Сүхбаатар	1673	1759.61	689	1594.9	41.18
16	043: Сэлэнгэ	4912	1084.7	2719	585.62	55.35
17	041: Төв	10321	13624.43	5690	8321.89	55.15
18	085: Увс	1565	4273.71	1176	3906.62	75.14
19	084: Ховд	1951	763.97	428	361.07	21.93
20	067: Хөвсгөл	1446	2472.66	978	322.16	67.63
21	023: Хэнтий	2636	475.27	1891	358.24	71.73
22	011: Улаанбаатар	45165	8352.02	21665	2556.5	47.9
<b>Нийт</b>		<b>88198</b>	<b>68978.81</b>	<b>46974</b>	<b>42282.66</b>	<b>53.25</b>

Дээрх хүснэгтээс үзэхэд Говьсүмбэр аймаг 89.6 хувь, Завхан аймаг 81,05 хувь, Өвөрхангай аймаг 76.39 хувь, Булган аймаг 75.31 хувь, Увс аймаг 75.14 хувь, Архангай аймаг 73.81 хувь, Хэнтий аймаг 71.73 хувь, Баян-Өлгий аймаг 69.15 хувь, Хөвсгөл 67.63 хувь, Орхон аймаг 67.59 хувь, Дорноговь аймаг 66.81 хувиар газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөгөө хангалттай сайн биелүүлсэн байна.

Харин Ховд аймгийн хэмжээнд газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тус ангиллын газар 21.93 хувьтай хэрэгжсэн байх бөгөөд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа газрыг өмчлөх, гэр орон сууцны хашааны зориулалтаар эзэмшүүлэх газрын биелэлт хангалтгүй, Дорнод аймаг 40.52 хувьтай хэрэгжүүлсэн бөгөөд орон сууцны зориулалтаар олгох газар, худалдаа үйлчилгээний зориулалтаар олгох газар, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дуудлага худалдаагаар эзэмшүүлэх, ухагдаж эвдэрсэн газрыг эргүүлэн дарж булах арга хэмжээнүүд нь хэрэгжээгүй байна.



Зураг 1.10.3. Хот, тосгон, бусад суурины газрын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт, байршлын тоогоор харуулсан байдал.



Зураг 1.10.4. Хот, тосгон бусад суурины газрын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг газрын хэмжээгээр харуулбал (га-гаар)

Хөдөө аж ахуйн газрын 2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

Улсын хэмжээнд сумдын газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөний хөдөө аж ахуйн ангиллын газарт нийт 15661 га байршил бүхий 4.9 сая га газрыг төлөвлөснөөс 9533 байршилд 4.3 сая га газрыг эзэмшүүлэх болон хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.


*Хүснэгт 1.10.5. Хөдөө аж ахуйн ангиллын газрын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал*

Д/д	Аймаг, нийслэл	2023 онд төлөвлөсөн		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь
		Нийт нэгж талбар	Нийт талбайн хэмжээ /га/	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	
1	065: Архангай	871	122.48	712	57.18	81.74
2	064: Баянхонгор	532	1,549,844.00	317	1,539,732.00	59.58
3	083: Баян-Өлгий	512	95,631.99	194	95577.5	37.89
4	063: Булган	535	76,180.38	350	56,167.20	65.42
5	082: Говь-Алтай	697	160,299.90	603	160,203.10	86.51
6	042: Говьсүмбэр	31	10806.9	31	10806.9	100
7	045: Дархан-Уул	123	160.86	69	49.37	59.06
8	044: Дорноговь	161	1532918	133	1497549	82.6
9	021: Дорнод	1538	391,441.60	671	61352.08	43.62
10	048: Дундговь	281	2,144.31	220	3,120.33	78.29
11	081: Завхан	665	308,684.60	433	305,686.40	65.11
12	062: Өвөрхангай	918	363417	598	225701.6	65.14
13	046: Өмнөговь	248	195.04	152	55.45	61.29
14	061: Орхон	100	63.69	79	54.37	79
15	022: Сүхбаатар	476	5290.54	75	53.91	15.75
16	043: Сэлэнгэ	1173	7,733.22	831	4,788.92	70.84
17	041: Төв	1854	171,879.09	1015	155,469.20	54.74
18	085: Увс	875	84,618.12	563	79,293.42	64.34
19	084: Ховд	975	2397.12	569	1518.39	58.35
20	067: Хөвсгөл	1337	20540.19	915	19780.76	68.443
21	023: Хэнтий	1435	151857	910	124549	63.41
22	011: Улаанбаатар	324	825.93	93	236.09	37.5
<b>Нийт</b>		<b>15661</b>	<b>4937051.96</b>	<b>9533</b>	<b>4341802.17</b>	<b>60.87</b>

Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөг хөдөө, аж ахуйн ангиллын газарт дараах аймгууд хангалттай сайн хэрэгжүүлсэн байна. Үүнд: Говьсүмбэр аймаг 100 хувь, Говь-Алтай аймаг 86.51 хувь, Архангай аймаг 81.74 хувь, Дорноговь аймаг 82.6 хувь, Орхон аймаг 79 хувь, Дундговь аймаг 78.29 хувь, Сэлэнгэ аймаг 70.84 хувьтай тус тус хангалттай сайн хэрэгжүүлэн ажилласан байна.

Сүхбаатар аймаг өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх нийт 452 байршилд 31.64 га газар төлөвлөснөөс 55 байршилд 3.85 га газрыг эзэмшүүлж, 12.17 хувийн хэрэгжилттэй байна. Иймд тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа суурин болон хээрийн судалгааны ажлыг үнэн бодитойгоор хийж, төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай байна.

Улсын хэмжээнд хөдөө, аж ахуйн ангиллын газрын хэрэгжилт **60.87** хувьтай байна.




Зураг 1.10.5. Хөдөө аж ахуйн газрын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг газрын хэмжээгээр, га-гаар



Хүснэгт 1.10.6. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хөдөө, аж ахуйн ангиллын газрын сүүлийн 3 жилийн хэрэгжилтийг хувиар харуулсан байдал

Д/д	Аймаг, нийслэлийн нэр	2021 он	2022 он	2023 он
1	Архангай	1.59	61.33	81.74
2	Баянхонгор	45.63	63.04	59.58
3	Баян-Өлгий	15.13	37.89	65.42
4	Булган	75.1	66.36	86.51
5	Говь-Алтай	80.45	87.5	100
6	Говьсүмбэр	0	60	100
7	Дархан-Уул	73.91	63.41	59.06
8	Дорнод	51.53	93.45	82.6
9	Дорноговь	94.96	32.78	43.62
10	Дундговь	44.37	74.93	78.29
11	Завхан	33	61.86	65.11
12	Орхон	88.89	77.16	65.14
13	Өвөрхангай	55.91	39.51	61.29
14	Өмнөговь	53.17	56.14	79
15	Сүхбаатар	31.05	55.26	77.75
16	Сэлэнгэ	31.55	56.23	70.84
17	Төв	15.31	54.29	58.35
18	Увс	42.42	54.32	68.443
19	Ховд	59.4	56.3	63.41
20	Хөвсгөл	48.99	77.75	63.41
21	Хэнтий	78.89	37.5	37.5
22	Улаанбаатар	36.21	37.5	37.5
	<b>Нийт</b>	<b>50.28</b>	<b>61.08</b>	<b>60.87</b>



Зураг 1.10.6. Хөдөө аж ахуйн газрын ангилалын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний сүүлийн 3 жилийн хэрэгжилт (хувиар)

Зам, шугам сүлжээний газрын 2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт


Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөнд нийт 420 байршилд 151.83 мянган га газар төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 225 байршилд 148.83 мянган га газрыг ашиглуулж, хамгаалснаар улсын хэмжээнд зам, шугам сүлжээний ангиллын газрын төлөвлөгөөний хэрэгжилт 53.57 хувьтай байна.

*Хүснэгт 1.10.7. Зам, шугам сүлжээний газрын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал*

Д/д	Аймаг, нийслэл	2023 онд төлөвлөсөн		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь
		Нийт нэгж талбар	Нийт талбайн хэмжээ /га/	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	
1	065: Архангай	2	3.15	1	0.04	50
2	064: Баянхонгор	13	352.63	6	2.39	46.15
3	083: Баян-Өлгий	7	262.19	2	1.16	28.57
4	063: Булган	13	0.4	6	0.19	46.15
5	082: Говь-Алтай	22	2040.29	17	1660.21	77.27
6	045: Дархан-Уул	23	4.7	13	4.2	56.52
7	044: Дорноговь	60	459.14	38	191.01	63.33
8	021: Дорнод	4	1.87	1	0.05	25
9	048: Дундговь	22	145,383.30	15	145340.4	68.18
10	081: Завхан	10	42.8	10	42.8	100
11	062: Өвөрхангай	30	989.64	16	682.72	53.33
12	046: Өмнөговь	44	611.33	34	396.02	77.27
13	022: Сүхбаатар	4	0.08	2	0.08	50
14	043: Сэлэнгэ	23	775.88	8	44.15	34.78
15	041: Төв	41	186.2	21	155.3	51.21
16	085: Увс	20	96.35	5	2.26	25
17	084: Ховд	15	610.59	6	298.38	40
18	067: Хөвсгөл	17	0.18	6	0.1	35.29
19	023: Хэнтий	4	0.05	2	0.03	50
20	011:Улаанбаатар	46	17.66	16	14.7	37.2
<b>Нийт</b>		<b>420</b>	<b>151838.43</b>	<b>225</b>	<b>148836.19</b>	<b>53.57</b>

Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний зам, шугам сүлжээний ангиллын газарт Завхан аймаг 100 хувь, Өмнөговь аймаг 77.27 хувь, Говь-Алтай аймаг 77.27 хувь, Дундговь аймаг 68.18 хувь, Дорноговь аймаг 63.33 хувь, Дархан-Уул аймаг 56.52 хувь, Өвөрхангай аймаг 53.33 хувь, Төв аймаг 51.21 хувь, Архангай аймаг 50 хувь, Сүхбаатар аймаг 50 хувь, Хэнтий аймаг 50 хувьтай хангалттай сайн хэрэгжүүлсэн байна.

Харин Дорнод аймаг 25 хувийн хэрэгжилттэй байх бөгөөд шинээр барих, өргөтгөх дулаан дамжуулах хоолойн төлөвлөлт, эрчим хүчний барилга байгууламжийн зориулалтаар ашиглах газрын төлөвлөлт, Увс аймаг 25 хувьтай, холбоо, мэдээлэл дамжуулах хүлээн авах шугам, станцын хамгаалалтын бүс тус тус төлөвлөсөн боловч хангалттай сайн хэрэгжээгүй байна.



Зураг 1.10.7. Зам, шугам сүлжээний зориулалтаар ашиглуулах, хамгаалах газрын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт газрын хэмжээгээр /га-гаар/

Ойн сан бүхий газрын 2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөнд нийт 831 байршилд 53.62 мянган га газар төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 404 байршилд 2.18 мянган

га газрыг ашиглуулж, хамгаалснаар улсын хэмжээнд ойн сан бүхий газрын ангиллын төлөвлөгөөний хэрэгжилт **48.61** хувьтай байна.


*Хүснэгт 1.10.8. Ойн сан бүхий газрын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал*

Д/д	Аймаг, нийслэл	2023 онд төлөвлөсөн		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь
		Нийт нэгж талбар	Нийт талбайн хэмжээ /га/	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	
1	064: Баянхонгор	10	18.62	4	8.74	40
2	083: Баян-Өлгий	10	5.13	1	4.73	10
3	063: Булган	33	42651.41	23	0.19	46.15
4	082: Говь-Алтай	7	39.19	7	39.19	100
5	045: Дархан-Уул	276	333.87	169	179.04	61.23
6	044: Дорноговь	4	26.16	4	26.16	100
7	021: Дорнод	19	3012.17	0	0	0
8	048: Дундговь	5	102.57	2	2.67	40
9	081: Завхан	48	265.28	7	55.49	14.58
10	062: Өвөрхангай	16	28.94	7	21.71	43.75
11	046: Өмнөговь	56	4925.26	39	957.01	69.64
12	061: Орхон	2	43.11	1	2.99	50
13	022: Сүхбаатар	4	113.93	0	0	0
14	043: Сэлэнгэ	74	570.88	24	57.11	32.43
15	041: Төв	26	140.74	3	11.9	11.53
16	085: Увс	23	200.72	20	197.89	86.95
17	084: Ховд	126	333.54	66	203.16	52.38
18	067: Хөвсгөл	7	23.56	6	6.34	85.71
19	023: Хэнтий	12	382.23	9	350.68	75
20	011: Улаанбаатар	73	409.86	12	56.56	16.43
<b>Нийт</b>		<b>831</b>	<b>53627.17</b>	<b>404</b>	<b>2181.56</b>	<b>48.61</b>

2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний ойн сан бүхий газрын ангиллын газарт дараах аймгууд хангалттай сайн хэрэгжүүлсэн байна. Үүнд: Говь-Алтай аймаг 100 хувь, Дорноговь аймаг 100 хувь, Увс аймаг 86.95, Хөвсгөл аймаг 85.71 хувь, Хэнтий аймаг 75 хувь, Өмнөговь аймаг 69.64 хувь, Дархан-Уул аймаг 61.23 хувь, хангалттай сайн хэрэгжүүлсэн байна.

Харин Дорнод аймаг өвчин, хортон шавьжтай тэмцэх ой бүхий газар, нөхөн сэргээх ойн талбай, Сүхбаатар аймаг мод үржүүлгийн газар байгуулахад тохиромжтой газар, тариалангийн талбайг хамгаалах ойн зурвас байгуулах газар, мод үржүүлгийн газар байгуулах газар тус тус төлөвлөсөн боловч хэрэгжээгүй байна.

Архангай аймаг, Говьсүмбэр аймаг ойн сан бүхий газрын ангилалд арга хэмжээ төлөвлөөгүй байна.



Зураг 1.10.8. Ойн сан бүхий газрын зориулалтаар ашиглуулах, хамгаалах газрын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт газрын хэмжээгээр /га-гаар/

Усны сан бүхий газрын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөнд нийт 59 байршилд 1.7 мянган га газар төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 37 байршилд 1.3 мянган га газарт хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлснээр улсын хэмжээнд усны сан бүхий газрын ангиллын төлөвлөгөөний хэрэгжилт 62.71 хувьтай байна.


Хүснэгт 1.10.8. Усны сан бүхий газрын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал.

Д/д	Аймаг, нийслэл	2023 онд төлөвлөсөн		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь
		Нийт нэгж талбар	Нийт талбайн хэмжээ /га/	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	
1	064: Баянхонгор	4	92.95	4	92.95	100
2	063: Булган	12	91.58	9	0.25	75
3	082: Говь-Алтай	2	0.63	2	0.63	100
4	021: Дорнод	4	0.73	4	0.73	100
5	048: Дундговь	1	126.28	0	0	0
6	062: Өвөрхангай	8	1.36	7	1.31	87.5
7	022: Сүхбаатар	1	53.89	0	0	0
8	043: Сэлэнгэ	2	4.22	0	0	0
9	041: Төв	3	0.21	0	0	0
10	067: Хөвсгөл	1	1.91	1	1.91	100
11	023: Хэнтий	13	1265.98	10	1265.01	76.92
12	011: Улаанбаатар	8	70.58	0	0	0
<b>Нийт</b>		<b>59</b>	<b>1710.32</b>	<b>37</b>	<b>1362.79</b>	<b>62.71</b>

2023 онд тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний усны сан бүхий газрын ангилалд дараах аймгууд хангалттай сайн хэрэгжүүлсэн байна. Үүнд: Баянхонгор аймаг 100 хувь, Говь-Алтай аймаг 100 хувь, Дорнод аймаг 100 хувь, Хөвсгөл аймаг 100 хувь, Өвөрхангай аймаг 87.5 хувь, Хэнтий аймаг 76.92 хувь, Булган аймаг 75 хувь хангалттай сайн хэрэгжүүлсэн байна.

Харин Дундговь аймаг усны эх булаг, эрэг орчмын газрыг хашиж хамгаалах, Сүхбаатар аймаг усны эх булаг, эрэг орчмын газрыг хашиж хамгаалах, Сэлэнгэ аймаг усны эх булаг, эрэг орчмын газрыг хашиж хамгаалах, хиймэл нуур, хөв, цөөрөм байгуулах газрын төлөвлөлт, Төв аймаг усан сан бүхий газрын хамгаалалтын бүс дэх зөвшөөрөгдсөн газар ашиглалт, Улаанбаатарт ус хангамжийн эх үүсвэр, рашааны орд, эх булгийн эрүүл ахуйн бүс тус тус төлөвлөсөн боловч хэрэгжээгүй байна.

Иймд тухайн жилийн төлөвлөгөө боловсруулахдаа суурин болон хээрийн судалгааны ажлыг оновчтой, үнэн, бодит төлөвлөх, хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлэж, газар зохион байгуулалт, төлөвлөлтийн цахим системд хамгаалах арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн гүйцэт оруулж хэвших шаардлагатай байна.



*Зураг 1.10.9. Усны сан бүхий газрын зориулалтаар ашиглуулах, хамгаалах газрын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт газрын хэмжээгээр /га-гаар/*

Дээрх төлөвлөгөөний хэрэгжилтийг газрын талбайн хэмжээгээр харуулсан зургаас үзэхэд Баянхонгор аймаг 4 байршилд 567.59 га газар төлөвлөснөөс 1 байршилд 567.16 га газарт усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг байгуулснаар талбайн хэмжээний биелэлт хангалттай боловч төлөвлөгөөнд тусгагдсан 3 байршилд хамгаалах арга хэмжээ хийгдээгүй тул хэрэгжилт хангалтгүй үзүүлэлттэй гарч байна. Иймд төлөвлөгөөний төслийг боловсруулахад хээрийн судалгааны ажлыг аргачлалын дагуу гүйцэтгэх нь зүйтэй юм.

*Тусгай хэрэгцээний газрын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт*

Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөнд нийт 177 байршилд 1.7 мянган га газар төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 46 байршилд 0.08 мянган га газрыг эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх, хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлснээр улсын хэмжээнд тусгай хэрэгцээний газрын ангиллын төлөвлөгөөний хэрэгжилт 61.63 хувьтай байна.


*Хүснэгт 1.10.9. Тусгай хэрэгцээний газрын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал*

Д/д	Аймаг, нийслэл	2023 онд төлөвлөсөн		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь
		Нийт нэгж талбар	Нийт талбайн хэмжээ /га/	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	
1	064: Баянхонгор	8	48.74	4	3.24	50
2	063: Булган	9	42.22	7	41.22	77.77
3	082: Говь-Алтай	5	1.65	0	0	0
4	045: Дархан-Уул	2	1.98	0	0	0
5	044: Дорноговь	1	0.91	0	0	0
6	021: Дорнод	71	65.56	0	0	0
7	048: Дундговь	2	1384.31	0	0	0
8	081: Завхан	29	15.8	14	9.58	48.28
9	062: Өвөрхангай	3	3	3	3	100
10	046: Өмнөговь	6	10.16	5	9.16	83.33
11	022: Сүхбаатар	2	2.06	0	0	0
12	043: Сэлэнгэ	9	71.35	2	5.53	22.22
13	041: Төв	15	30.8	8	13.8	53.33
14	085: Увс	8	21.7	1	0.02	12.5
15	067: Хөвсгөл	4	3.01	0	0	0
16	011: Улаанбаатар	3	2.86	2	2	66.66
<b>Нийт</b>		<b>177</b>	<b>1706.11</b>	<b>46</b>	<b>87.55</b>	<b>25.98</b>

Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тусгай хэрэгцээний газрын ангиллын газрын биелэлтийг үзэхэд Өвөрхангай аймаг 100 хувь, Өмнөговь аймаг 83.33 хувь, Булган аймаг 77.77 хувь, Улаанбаатар 66.66 хувь, Төв аймаг 53.33 хувь, Завхан аймаг 48.28 хувь, хангалттай сайн хэрэгжүүлсэн байна.

Харин Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Сүхбаатар, Хөвсгөл аймгууд төлөвлөсөн арга хэмжээнээсээ хэрэгжүүлээгүй байна.






Зураг 1.10.10. Тусгай хэрэгцээний газрын зориулалтаар эзэмшүүлж, ашиглуулж, өмчлүүлж, хамгаалсан арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт газрын хэмжээгээр /га-гаар/

### 2024 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө

Улсын хэмжээнд нийт 330 сум, 9 дүүргээс 2023 оны 01 дугаар сарын 19-ны өдрийн байдлаар газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системээс тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулсан байдлыг

үзэхэд төлөвлөгөөгөө баталсан 263 сум, баталгаажуулах шатанд 39, төсөл боловсруулах шатанд 38 байна.




Зураг 1.10.11. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний явцыг зургаар харуулсан байдал

Хүснэгт 1.10.10. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл үүсгэсэн байдлыг аймаг, нийслэлээр харуулсан байдал.

Д/д	Аймаг, нийслэлийн нэр	Сум, дүүргийн тоо	Төлөвлөгөөний явц			
			Батлагдсан	Баталгаажуулах	Төсөл боловсруулах	Төсөл үүсгээгүй
1	Архангай	19	16	-	3	-
2	Баян-Өлгий	13	10	-	3	-
3	Баянхонгор	20	20	-	-	-
4	Булган	16	16	-	-	-
5	Говь-Алтай	18	18	-	-	-
6	Говьсүмбэр	3	2	1	-	-
7	Дархан-Уул	4	4	-	-	-
8	Дорноговь	14	13	1	-	-
9	Дорнод	14	13	1	-	-
10	Дундговь	15	15	-	-	-
11	Завхан	24	22	1	1	-
12	Орхон	2	2	-	-	-
13	Өвөрхангай	19	19	-	-	-
14	Өмнөговь	15	15	-	-	-
15	Сүхбаатар	13	6	3	4	-
16	Сэлэнгэ	17	8	9	-	-
17	Төв	27	-	19	8	-
18	Увс	19	15	1	3	-
19	Ховд	17	3	4	10	-
20	Хөвсгөл	23	23	-	-	-
21	Хэнтий	18	17	-	1	-
22	Улаанбаатар	10	6	-	4	-

Нийт	340	263	40	37	-
------	-----	-----	----	----	---

Улсын хэмжээнд 2024 оны нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний баталсан болон боловсруулсан төслөөс үзэхэд газрын нэгдмэл сангийн ангилалд нийт 46966 байршилд 6.89 сая га газрыг эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх, хамгаалах, нөхөн сэргээхээр төлөвлөсөн байна. Үүнээс хөдөө, аж ахуйн ангиллын газарт 10707 байршилд 6.45 сая га, хот, тосгон бусад суурины газарт 35269 байршилд 68.5 мянган га, зам, шугам сүлжээний газарт 404 байршилд 190.8 мянган га, ойн сан бүхий газарт 401 байршилд 64.6 мянган га, усны сан бүхий газарт 60 байршилд 1.31 мянган га, тусгай хэрэгцээний газарт 125 байршилд 110 мянган га газрыг тус тус төлөвлөсөн байна.



Зураг 1.10.12. Газрын нэгдмэл сангийн ангиллаар тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг харуулсан байдал (нэгж талбарын тоогоор).

Дээрх графикаас үзэхэд тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хот, тосгон бусад суурины ангиллын газарт 75.09 хувь, хөдөө, аж ахуйн ангиллын газарт 22.8 хувь, ойн сан бүхий ангиллын газарт 0.85 хувь, зам шугам сүлжээний ангиллын газарт 0.86 хувь, тусгай хэрэгцээний ангиллын газарт 0.27, усны сан бүхий ангиллын газарт 0.13 хувиар газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчүүлэх, хамгаалах, нөхөн сэргээхээр тус тус төлөвлөсөн байна.

жилийн төлөвлөгөөг газрын нэгдмэл сангийн ангиллаар харуулбал:

Д/Д	Аймаг, нийслэлийн нэр	Хөдөө, аж ахуйн газар		Хот, тосгон бусад суурины газар		Зам, шугам сүлжээний газар		Ойн сан бүхий газар		Усны сан бүхий газар		Тусгай хэрэгцээний газар	
		Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га-гаар	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га-гаар	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га-гаар	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га-гаар	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га-гаар	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га-гаар
1	065: Архангай	337	589.56	629	149.81	-	-	-	-	-	-	-	-
2	064: Баянхонгор	420	1493807	1909	13116.36	7	813.87	9	21.35	4	383.74	-	-
3	083: Баян-Өлгий	756	100	1100	109.27	-	-	3	30.97	-	-	2	<b>1379.11</b>
4	063: Булган	485	26502.79	2422	1673.72	4	63.37	8	217.59	5	0.03	13	<b>14.65</b>
5	082: Говь-Алтай	425	154663.52	648	1647.64	3	35.15	29	19.1	-	-	5	<b>1.62</b>
6	042: Говьсүмбэр	-	-	81	477.79	-	-	-	-	-	-	-	-
7	045: Дархан-Уул	52	123.11	2369	486.5	18	13.76	4	3.5	-	-	4	<b>6.75</b>
8	044: Дорноговь	204	2686358	802	1302.44	27	177678.5	-	-	-	-	5	<b>6651.09</b>
9	021: Дорнод	654	358888.2	1954	3747.29	3	565.5	21	3061.7	3	0.29	13	<b>104.71</b>
10	048: Дундговь	266	276738.52	1407	8045.39	8	89.42	5	98.21	-	-	-	-
11	081: Завхан	714	147114.6	926	2471.41	2	0.83	14	4754.57	-	-	13	<b>39001.76</b>
12	062: Өвөрхангай	973	367325.77	4796	5714.76	8	1.07	3	19	9	2.05	1	<b>97.89</b>
13	046: Өмнөговь	249	108.59	6511	7398.59	68	11354.98	21	138.07	2	28	10	<b>14.53</b>
14	061: Орхон	59	55.32	1029	5263.88	-	-	-	-	-	-	-	-
15	022: Сүхбаатар	20	263325.43	274	57.95	3	0.1	1	108.88	5	54.01	-	-
16	043: Сэлэнгэ	1191	143746.8	2519	6973.77	28	156.12	19	72.77	2	5.22	11	<b>23.55</b>
17	041: Төв	397	58096.9	687	4615.24	14	22.099	6	88.819	1	72.17	5	<b>62630.5</b>
18	085: Увс	664	351,457	404	3,632	10	2.44	20	279.5	21	767.29	16	<b>25</b>
19	084: Ховд	519	849.61	787	445.58	2	0.08	171	413.98	-	-	-	-
20	067: Хөвсгөл	1377	18717.17	2118	752.59	32	1.66	28	38528.36	-	-	17	<b>60.9</b>
21	023: Хэнтий	911	110362.9	1820	335.89	20	12.53	32	16753.45	8	6.26	10	<b>5.14</b>
22	011:Улаанбаатар	34	49.293	77	144.59	147	0.0561	7	19.345	-	-	-	-
<b>Нийт</b>		<b>10707</b>	<b>6458980.5</b>	<b>35269</b>	<b>68562.66</b>	<b>404</b>	<b>190811.54</b>	<b>401</b>	<b>64629.164</b>	<b>60</b>	<b>1319.06</b>	<b>125</b>	<b>110017.43</b>

## 2.ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТАЙЛАН

### 2.1.ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН АНГИЛАЛ, ГАЗАР АШИГЛАЛТЫН ТӨРӨЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, ШИЛЖИЛТИЙН ҮНДЭСЛЭЛ /МАЯГТ ГНСТ-1, 2, 4/

Газрын нэгдмэл сангийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 432 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын нэгдмэл сангийн тайлан эрхлэх журам”-ын хавсралтаар шинэчлэгдсэн маягтын дагуу газрын нэгдмэл сангийн ангиллын тайланг гаргалаа.

Өмнөх онуудад газрын нэгдмэл сангийн ангиллын тайланг хөдөө аж ахуйн газар, хот, тосгон бусад суурины газар, зам, шугам, сүлжээний газар, ойн сан бүхий газар, усны сан бүхий газар, улсын тусгай хэрэгцээний газар гэсэн үндсэн 6 ангиллын дагуу тайлагнадаг байсан бөгөөд 2022 онд “Газрын нэгдмэл сангийн тайлан гаргах журам” шинэчлэгдэн батлагдсанаар улсын тусгай хэрэгцээний газарт авсан нийт 26082.0 мянган га бүхий газрыг үндсэн ангилалд хамруулж тайлагнахаар болсон.

Иймд улсын тусгай хэрэгцээний газарт авсан нийт 26082.0 мянган га талбай бүхий газарт хамаарч байгаа хөдөө аж ахуйн газар 20723.4 мянга га, хот, тосгон бусад суурины газрын 23.6 мянган га, зам, шугам сүлжээний газрын 23.1 мянга га, ойн сан бүхий газрын 3950.8 мянган га, усны сан бүхий 1361.1 мянган га газрыг тус тус үндсэн ангилалд хамааруулснаар хөдөө аж ахуйн газар 13 хувиар, хот, тосгон бусад суурины газар 0.01 хувиар, , зам, шугам сүлжээний газар 0.01 хувиар, ойн сан бүхий газар 2.5 хувиар усны сан бүхий газар 0.9 хувиар тус тус нэмэгдсэн дүнтэй болж байна.

*Хүснэгт 2.1.1. Улсын газрын нэгдмэл сангийн ангиллын өөрчлөлтийн товч /га-гаар/*

Газрын нэгдмэл сангийн ангиллын код		Улсын тусгай хэрэгцээний газраас бусад ангиллын газар/ га-аар	Улсын тусгай хэрэгцээний газар/ га-аар	2022 оны нийт талбайн хэмжээ /га-аар/
<b>1</b>	<b>Хөдөө аж ахуйн газар</b>	113567.1	20723.4	134290.5
1.1	Бэлчээр	109151.3	20466.4	129617.7
1.2	Хадлан	1709.1	235.6	1944.8
1.3	Усалгаатай тариалан	0.0	0	0.0
1.4	Усалгаагүй тариалан	1139.9	14.8	1154.7
1.5	Атаршсан газар	215.5	2.4	217.9
1.6	ХАА-н барилга, байгууламжийн газар	91.4	0.6	92.1
1.7	Ашиглахад тохиромжгүй газар	1259.9	3.4	1263.3
<b>2</b>	<b>Хот тосгон, бусад суурин газар</b>	1005.3	23.6	1028.9
2.1	Барилга, байгууламжийн газар	67.3	14.8	82.0
2.2	Суурьшлын газар	90.4	1.1	91.5
2.3	Үйлдвэрийн газар	47.3	0.02	47.3
2.4	Нийтийн эдэлбэрийн газар	317.7	5.7	323.4
2.5	Амралт, аялал жуулчлалын газар	16.2	0	16.2
2.6	Уурхайн газар	466.4	2.0	468.4
2.7	Хот суурин доторх бүх төрлийн зам, тэдгээрийн барилга байгууламжийн газар	0.0	0	0.0

2.8	Хот суурин доторх инженерийн дэд бүтцийн зориулалтын газар	0.0	0	0.0
2.9	Цаашид тэлж хөгжих нөөц газар	0.0	0	0.0
<b>3</b>	<b>Зам, шугам сүлжээний газар</b>	<b>836.0</b>	<b>23.1</b>	<b>859.1</b>
3.1	Төмөр замын газар	35.7	6.6	42.3
3.2	Авто замын газар	331.2	14.9	346.1
3.3	Агаарын тээврийн газар	9.7	0.9	10.6
3.4	Шугам сүлжээний газар	459.5	0.6	460.1
3.5	Усан тээврийн газар	0.0	0	0.0
<b>4</b>	<b>Ойн сан бүхий газар</b>	<b>14260.3</b>	<b>3950.8</b>	<b>18211.1</b>
4.1	Ой модоор бүрхэгдсэн газар	12175.4	3351.1	15526.5
4.2	Ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй газар	2084.9	599.6	2684.5
<b>5</b>	<b>Усны сан бүхий газар</b>	<b>660.9</b>	<b>1361.1</b>	<b>2022.0</b>
5.1	Усны сан бүхий газар	221.3	53.6	274.9
5.2	Булаг, шанд	13.2	0	13.2
5.3	Нуур, цөөрөм, тойром	423.8	1293.8	1717.6
5.4	Мөнх цас, мөсөн гол	2.6	13.7	16.3
5.5	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс	0.0	0	0.0
<b>Нийт</b>		<b>130329.5</b>	<b>26082.0</b>	<b>156411.6</b>

Монгол Улсын газрын нэгдмэл санд хөдөө аж ахуйн газар 134076.2 мянган га буюу 85.7 хувь, хот, тосгон бусад суурины газар 1232.6 мянган га буюу 0.8 хувь, зам, шугам сүлжээний газар 869.9 мянган га буюу 0.6 хувь, ойн сан бүхий газар 18211.1 мянган га буюу 11.6 хувь, усны сан бүхий газар 2022.0 мянган га буюу 1.3 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.1/.



Зураг 2.1.1: Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын тус бүрийн эзлэх хувь

Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайлангийн дүнг 2022 оны дүнтэй харьцуулахад хөдөө аж ахуйн газар 214.5 мянган га-аар хасагдаж, хот тосгон, бусад суурины газар 203.7 мянган га, зам, шугам сүлжээний газар 10.8 мянган га-аар тус тус нэмэгдсэн байна. Ойн сан бүхий газар, усны сан бүхий газарт өөрчлөлт ороогүй байна /Хүснэгт 2.1.1/.

Хүснэгт 2.1.1. Улсын газрын нэгдмэл сангийн ангиллын өөрчлөлтийн товч /мянган га-аар/


Газрын нэгдмэл сангийн ангиллын код		2022 он /мян.га-аар/	2023 он /мян.га-аар/	Өөрчлөлт /мян.га-аар/
<b>1</b>	<b>Хөдөө аж ахуйн газар</b>	134290.5	134076.0	-214.5
1.1	Бэлчээр	129617.7	129369.5	-248.2
1.2	Хадлан	1944.8	1945.0	0.2
1.3	Усалгаатай тариалан	0.0	21.7	21.7
1.4	Усалгаагүй тариалан	1154.7	1161.9	7.2
1.5	Атаршсан газар	217.9	218.0	0.1
1.6	ХАА-н барилга, байгууламжийн газар	92.1	96.6	4.5
1.7	Ашиглахад тохиромжгүй газар	1263.3	1263.3	0.0
<b>2</b>	<b>Хот тосгон, бусад суурин газар</b>	1028.9	1232.6	203.7
2.1	Барилга, байгууламжийн газар	82.0	250.9	168.9
2.2	Суурьшлын газар	91.5	96.8	5.3
2.3	Үйлдвэрийн газар	47.3	47.9	0.5
2.4	Нийтийн эдэлбэрийн газар	323.4	315.6	-7.8
2.5	Амралт, аялал жуулчлалын газар	16.2	16.7	0.5
2.6	Уурхайн газар	468.4	502.7	34.2
2.7	Хот суурин доторх бүх төрлийн зам, тэдгээрийн барилга байгууламжийн газар	0.0	2.0	2.0
2.8	Хот суурин доторх инженерийн дэд бүтцийн зориулалтын газар	0.0	0.0	0.0
2.9	Цаашид тэлж хөгжих нөөц газар	0.0	0.0	0.0
<b>3</b>	<b>Зам, шугам сүлжээний газар</b>	859.1	869.9	10.8
3.1	Төмөр замын газар	42.3	42.3	0.0
3.2	Авто замын газар	346.1	354.6	8.5
3.3	Агаарын тээврийн газар	10.6	10.6	0.0
3.4	Шугам сүлжээний газар	460.1	462.3	2.2
3.5	Усан тээврийн газар	0.0	0.0	0.0
<b>4</b>	<b>Ойн сан бүхий газар</b>	18211.1	18211.1	0.0
4.1	Ой модоор бүрхэгдсэн газар	15526.5	15606.4	79.9
4.2	Ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй газар	2684.5	2604.7	-79.9
<b>5</b>	<b>Усны сан бүхий газар</b>	2022.0	2022.0	0.0
5.1	Усны сан бүхий газар	274.9	274.9	0.0
5.2	Булаг, шанд	13.2	13.2	0.0
5.3	Нуур, цөөрөм, тойром	1717.6	1717.6	0.0
5.4	Мөнх цас, мөсөн гол	16.3	16.3	0.0
5.5	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс	0.0	0.0	0.0
<b>Нийт</b>		<b>156411.6</b>	<b>156411.6</b>	<b>156411.6</b>

### 2.1.1.Хөдөө аж ахуйн газар

Хөдөө аж ахуйн газар 134076.0 га буюу нийт нутаг дэвсгэрийн 85.7 хувийг эзэлж байна.

Хөдөө аж ахуйн газарт бэлчээрийн газар 129369.5 мянган га буюу 96.5 хувь, хадлангийн газар 1945.0 мянган га буюу 1.4 хувь, усалгаатай тариалангийн газар 21.7 мянган га буюу 0.02 хувь, усалгаагүй тариалангийн газар 1161.9 мянган га буюу

0.87 хувь, атаршсан газар 218.0 мянган га буюу 0.16 хувь, хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр газар 96.6 мянган га буюу 0.07 хувь, ашиглахад тохиромжгүй газар 1263.3 мянган га буюу 0.9 хувийг тус тус эзэлж байна.



Зураг 2.1.1.1: Хөдөө аж ахуйн газрын эзлэх хувь

Хүснэгт 2.1.1.1: Хөдөө аж ахуйн газрын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2022	2023	Зөрүү /мян га/
I	<b>Хөдөө аж ахуйн газар</b>	134290.5	134076.0	-214.5
1	Бэлчээрийн газар	129617.7	129369.5	-248.2
2	Хадлангийн талбай	1944.8	1945.0	0.2
3	Усалгаатай тариалан	0.0	21.7	21.7
4	Усалгааагүй тариалан	1154.7	1161.9	7.2
5	Атаршсан газар	217.9	218.0	0.1
6	ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар	92.1	96.6	4.5
7	Ашиглахад тохиромжгүй газар	1263.3	1263.3	0.0

### Бэлчээрийн газар

Бэлчээрийн газар нь 2022 оны тайлангийн дүнтэй харьцуулахад Дундговь аймгийн Сайнцагаан суманд 47.5 мянган га, Луус суманд 144.8 мянган га, Өмнөговь аймгийн Цогтцэций суманд 20.4 мянган га газрыг барилга, байгууламжийн дэвсгэр газарт, Баянхонгор аймагт 8.5 мянган га, Дорноговь аймагт 9.0 мянган га, Дорнод аймагт 0.9 мянган га, Дундговь аймагт 6.2 мянган га, Өмнөговь аймагт 4.0 мянган га, Төв аймагт 7.0 мянган га газруудыг уурхайн дэвсгэр газарт, Булган аймагт 1.3 мянган га газруудыг тариалангийн газарт шилжүүлж томоохон өөрчлөлт орсон байна.

Харин бэлчээрийн газарт нэмэгдсэн газар байхгүй байна.

### Хадлангийн газар

Хадлангийн газар нийтдээ 0.2 мянган га-аар нэмэгдсэн байгаа нь Ховд аймагт 99.9 га, Дорнод аймагт 20 га, Говь-Алтай аймагт 20.1 га, Увс аймагт 5 га газрыг тус тус усалгаатай хадлан зориулалтаар ашигласнаар нэмэгдэж бүртгэгдсэн байна.




Тариалангийн газар

Тариалангийн газар нь 2022 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 28.9 мянган га-гаар нэмэгдсэн байна. Тариалангийн газрын хувьд Ховд аймагт 14000 га, Төв аймагт 1496.2 га газрыг тэжээлийн ургамал тарих зориулалтаар, Говь-Алтай аймагт 1590 га газрыг төмс, хүнсний ногоо тарих зориулалтаар тус тус ашигласнаар Улсын хэмжээнд тариалангийн газар нэмэгдэж бүртгэгдсэн байна /Хүснэгт 2.1.1.2/.

Хүснэгт 2.1.1.2: Тариалангийн газрын өөрчлөлт /га/

№	Аймгийн нэр	2022 он /мян.га-аар/	2023 оон /мян.га-аар/	Зөрүү /мян.га-аар/
1	Архангай	30.4	30.6	0.3
2	Баянхонгор	3.8	4.1	0.3
3	Баян-Өлгий	3.4	3.4	0.0
4	Булган	90.8	92.0	1.2
5	Говь-Алтай	8.2	9.9	1.6
6	Говьсүмбэр	0.5	0.5	0.0
7	Дархан-Уул	34.4	34.4	0.0
8	Дорноговь	1.3	1.4	0.1
9	Дорнод	98.8	99.2	0.5
10	Дундговь	0.9	1.0	0.0
11	Завхан	21.6	22.8	1.2
12	Орхон	5.2	5.2	0.0
13	Өвөрхангай	26.9	26.9	0.0
14	Өмнөговь	3.1	3.2	0.0
15	Сүхбаатар	17.7	17.7	0.1
16	Сэлэнгэ	317.4	318.0	0.5
17	Төв	265.9	270.7	4.8
18	Увс	84.9	86.3	1.4
19	Ховд	15.8	31.2	15.3
20	Хөвсгөл	33.8	34.2	0.4
21	Хэнтий	81.8	82.3	0.5
22	Нийслэл	8.1	8.7	0.6
<b>Нийт дүн</b>		<b>1154.7</b>	<b>1183.6</b>	<b>28.9</b>

Тариалангийн газрын зориулалтаар 1990 оноос хойшхи хугацаанд ашиглагдаж буй талбайн Улсын хэмжээний дүнг дараах зурагт үзүүлэв /Зураг 2.1.1.2/.



Зураг 2.1.1.2: Тариалангийн газрын өөрчлөлт /мян.га/

**Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар**


Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар улсын хэмжээнд нийтдээ 4.5 мянган га-гаар бэлчээрийн газраас тус тус нэмэгдсэн дүнтэй байна.

Ашиглахад тохиромжгүй газарт тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

**2.1.2.Хот, тосгон, бусад суурины газар**

Хот, тосгон бусад суурины газар 1232.6 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.8 хувийг эзэлж байна.

Хот, тосгон, бусад суурины газарт барилга, байгууламжийн дэвсгэр газар 250.9 мянган га буюу 20.4 хувийг, суурьшлын газар 96.8 мянган га буюу 7.9 хувийг, үйлдвэрийн газар 47.9 мянган га буюу 3.9 хувийг, нийтийн эдэлбэр газар 315.6 мянган га буюу 3.9 хувийг, амралт аялал жуулчлалын газар 16.7 мянган га буюу 1.4 хувийг, уурхайн газар 502.7 мянган га буюу 40.8 хувийг хот суурин доторх бүр төрлийн зам, тэдгээрийн барилга байгууламжийн газар 2 га буюу 0.2 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.2.1/.



Зураг 2.1.2.1: Хот тосгон, бусад суурин газрын эзлэх хувь


Хүснэгт 2.1.2.1. Хот, тосгон, бусад суурин газрын өөрчлөлт /га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2022	2023	Өөрчлөлт / га/
II	Хот, тосгон бусад суурины газар	1028.9	1232.6	203.7
8	Барилга, байгууламжийн газар	82.0	250.9	168.9
9	Суурьшлын газар	91.5	96.8	5.3
10	Үйлдвэрийн газар	47.3	47.9	0.5
11	Нийтийн эдэлбэр газар	323.4	315.6	-7.8
12	Амралт аялал жуулчлалын газар	16.2	16.7	0.5
13	Уурхайн газар	468.4	502.7	34.2
14	Хот суурин доторх бүх төрлийн зам, тэдгээрийн барилга байгууламжийн газар	0.0	2.0	2.0
15	Хот суурин доторх инженерийн дэд бүтцийн зориулалтын газар	0.0	0.0	0.0
16	Цаашид тэлж хөгжих нөөц газар	0.0	0.0	0.0

### 2.1.3.Зам, шугам сүлжээний газар

Зам, шугам сүлжээний газар 869.9 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.6 хувийг эзэлж байгаа бөгөөд 2022 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 10.8 га-гаар нэмэгдсэн байна /Хүснэгт 2.1.3.1/.

Зам, шугам сүлжээний газарт төмөр замын газар 42.3 га буюу 4.9 хувийг, авто замын газар 354.6 га буюу 40.8 хувийг, агаарын тээврийн газар 10.6 мянган га буюу 1.2 хувийг, шугам сүлжээний газар 462.3 мянган га буюу 53.1 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.3.1/.



Зураг 2.1.3.1: Зам, шугам сүлжээний газрын эзлэх хувь


Хүснэгт 2.1.3.1: Зам, шугам, сүлжээний газрын ангиллын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2022	2023	Өөрчлөлт /мян га/
III	Зам, шугам сүлжээний газар	859.1	869.9	10.8
17	Төмөр замын газар	42.3	42.3	0.0
18	Авто замын газар	346.1	354.6	8.5
19	Агаарын тээврийн газар	10.6	10.6	0.0
20	Шугам сүлжээний газар	460.1	462.3	2.2
21	Усан тээврийн газар	0.0	0.0	0.0

#### 2.1.4. Ойн сан бүхий газар

Ойн сан бүхий газар 18211.1 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 11.6 хувийг эзэлж байна.

Ойн сан бүхий газарт ойгоор бүрхэгдсэн газар 15606.4 мянган га буюу 85.7 хувийг, ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй газар 2604.7 мянган га буюу 14.3 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.4.1/.



Зураг 2.1.4.1: Ойн сан бүхий газрын эзлэх хувь


Хүснэгт 2.1.4.1: Ойн сан бүхий газрын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2022	2023	Өөрчлөлт /га/
IV	Ойн сан бүхий газар	18211.1	18211.1	0.0
17	Ой модоор бүрхэгдсэн газар	15526.5	15606.4	79.9
18	Ой дотор байгаа ойгоо бүрхэгдээгүй газар	2684.5	2604.7	-79.9

### 2.1.5. Усны сан бүхий газар

Усны сан бүхий газар 2022.0 мянган га буюу нийт газар нутгийн 1.3 хувийг эзэлж байна.

Усны сан бүхий газарт мөрөн, гол, горхи 274.9 мянган га буюу 13.6 хувийг, нуур, цөөрөм 1717.6 мянган га буюу 84.9 хувийг, булаг, шанд 13.2 га буюу 0.7 хувийг, мөнх цас, мөсөн гол 16.3 га буюу 0.8 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.5.1/.



Зураг 2.1.5.1: Усны сан бүхий газрын эзлэх хувь


Хүснэгт 2.1.5.1: Усны сан бүхий газрын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2021	2022	Өөрчлөлт /мян га/
V	Усны сан бүхий газар	2022.0	2022.0	0.0
24	Мөрөн, гол горхи	274.9	274.9	0.0
25	Булаг шанд	13.2	13.2	0.0
26	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	1717.6	1717.6	0.0
27	Мөнх цас, мөсөн голын эзлэх газар	16.3	16.3	0.0
28	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс	0.0	0.0	0.0

Усны сан бүхий газрын хэмжээнд 2023 онд өөрчлөлт ороогүй байна.

## 2.2.УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР /МАЯГТ ГНСТ-3/

2023 оны байдлаар улсын тусгай хэрэгцээний газрын нийт хэмжээ 32 сая 237 мянган га талбай буюу улсын нийт нутаг дэвсгэрийн 20.6 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оныхоос 3.94 хувиар өссөн байна.



Зураг 2.2.1. Улсын тусгай хэрэгцээний газрын эзлэх хувь

Улсын тусгай хэрэгцээний газрын ангилалд улсын тусгай хамгаалалттай газар 21 сая 927 мянган га буюу 68.01 хувийг, улсын хилийн зурвас газар 9 сая 244701 мянган га буюу 28.6 хувийг, улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар 124.1 мянган га буюу 0.38 хувийг, гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар 37.6 га буюу 0.0001 хувийг, шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай 36.1 мянган га буюу 0.11 хувийг, аймаг дундын отрын бэлчээр 691.4 мянган га буюу 2.14 хувийг, улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай 110.9 мянган га буюу 0.34 хувийг, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай 45.8 мянган га буюу 0.14 хувийг, чөлөөт бүсийн газар 2.1 мянган га буюу 0.006 хувийг, үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх


газар 55.5 мянган га буюу 0.17 хувийг, аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар 22 га буюу 0.0001 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант онд улсын хэмжээнд 9 сая 266093 мянган га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан байна. Үүнд:

- Улсын Их Хурлын 2022 оны мн/81 дүгээр тогтоолоор нийт 9,244,701 мянган га газрыг Улсын хилийн зурвас газрын зориулалтаар;
- Засгийн газрын 2023 оны 265 дугаар тогтоолоор Дорнод аймгийн Матад суманд “Матад ХХ” талбайн 21392 га бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбайн зориулалтаар;
- Засгийн газрын 2023 оны 145 дугаар тогтоолоор "Монгол ган цогцолбор I" төсөл хэрэгжүүлэх зориулалтаар Дархан-Уул аймгийн Дархан, Хонгор сумдын нутаг дэвсгэрт нийт 77.7 га газрыг Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газрын зориулалтаар тус тус улсын тусгай хэрэгцээнд авсан байна.

*Хүснэгт 2.2.1. Улсын тусгай харэгцээний газрын өөрчлөлт /га/*

Д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	2022	2023	Зөрүү
VI	Улсын тусгай хэрэгцээний газар	26,082,039.58	32,237,849.46	6,155,809.88
1	Улсын тусгай хамгаалалттай газар, бүгд	21,926,998.72	21,926,998.72	-
а	дархан цаазат газар	10,919,403.0	10,919,403.0	-
б	байгалийн цогцолборт газар	8,883,939.1	8,883,939.1	-
в	байгалийн нөөц газар	2,044,351.6	2,044,351.6	-
г	дурсгалт газар	79,305.0	79,305.0	-
2	Улсын хилийн зурвас газар	3,110,340.89	9,244,701	6,134,360.11
3	Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	124,097.61	124,097.61	-
4	Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар	37.62	37.62	-
5	Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	36,125.64	36,125.64	-
6	Аймаг дундын отрын бэлчээр	691,413.80	691,413.80	-
7	Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай	110,940.00	110,940.00	-
8	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай	24,470.00	45,862.0	21,392.00
9	Чөлөөт бүсийн газар	2,108.40	2,108.40	-
10	Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар	55,464.90	55,542.61	77,7
11	Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар	42,00	22,00	20,00



Зураг 2.2.2. Улсын тусгай хэрэгцээний газрын ангиллын талбайн хэмжээ /га/

Энэхүү өөрчлөлтөөр хөдөө аж ахуйн газраас 7 сая 172 мянган га, хот тосгон, бусад суурины газраас 41343 га, зам, шугам сүлжээний газраас 30475 га, ойн сан бүхий газраас 1 сая 894 мянган га, усны сан бүхий газраас 106613 га газар тус тус улсын тусгай хэрэгцээний газрын ангилалд шилжсэн байна.

Хүснэгт 2.2.2. Улсын тусгай хэрэгцээний газрын ангилалд шилжсэн газрууд /га/


Газрын нэгдмэл сангийн ангилал		Талбайн хэмжээ /сая.га/
Хөдөө аж ахуйн газар	Бүгд	7,172,108
	Бэлчээр	7,130,594
	Хадлан	29987
	Усалгаатай тариалан	30515
	Усалгаагүй тариалан	-
	Атаршсан газар	893
	ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар	10
	Ашиглахад тохиромжгүй газар	1499
Хот тосгон, бусад суурины газар	Бүгд	41343
	Барилга, байгууламжийн газар	15641
	Суурьшлын газар	7087
	Үйлдвэрийн газар	2645,7
	Нийтийн эдэлбэрийн газар	210



	Амралт, аялал жуулчлалын газар	452
	Уурхайн газар	14226
	Хот суурин доторх бүх төрлийн зам, тэдгээрийн барилга байгууламжийн газар	-
	Хот суурин доторх инженерийн дэд бүтцийн зориулалтын газар	-
	Цаашид тэлж хөгжих нөөц газар	1157
Зам, шугам сүлжээний газар	Бүгд	30475
	Төмөр замын газар	1051
	Авто замын газар	28408
	Агаарын тээврийн газар	-
	Шугам сүлжээний газар	1015
	Усан тээврийн газар	-
Ойн сан бүхий газар	Бүгд	1,894,160
	Ойн сан бүхий газар	1,609,236
	Ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй газар	284923
Усны сан бүхий газар	Бүгд	106613
	Усны сан бүхий газар	79254
	Булаг, шанд	162
	Нуур, цөөрөм, тойром	15144
	Мөнх цас, мөсөн гол	9570
	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс	2483
<b>Нийт дүн</b>		<b>9,244,699</b>

### 2.3.ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГНСТ-5/


Улсын хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 3058825.59 га газрыг иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгоод байна. Үүнээс 62139.22 га газрыг өмчилж, 2236739.36 га газрыг эзэмшиж, 759947.01 га газрын ашиглаж байна /Зураг 2.3.1/.



Зураг 2.3.1. 2023 оны байдлаар өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газар /хувиар/


Улсын хэмжээнд иргэн, хуулийн этгээдэд олгосон газрыг эрхийн төрлөөр нь ангилбал Монгол Улсын иргэнд 62139.22 га газрыг өмчлөх эрхтэйгээр, Монгол Улсын иргэнд 340986.33 га, аж ахуйн нэгжид 1808029.67 га, төрийн байгууллагад

87723.37 га газрыг тус тус эзэмших эрхтэйгээр, Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд 560470.64 га, гадаадын хуулийн этгээдэд 367.13 га, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид 199097.47 га, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд 11.76 га газрыг тус тус ашиглах эрхтэйгээр олгоод байна.



Зураг 2.3.2. 2023 оны байдлаар иргэн, хуулийн этгээдэд олгосон газрын талбайн хэмжээ

Иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгосон газрыг засаг захиргааны нэгжээр ангилбал Өмнөговь аймаг 579.2 мянга га, Дундговь аймаг 561.3 мянган га, Төв аймаг 382.8 га талбайгаар тэргүүлж байна.



Зураг 2.3.2. Иргэн, хуулийн этгээдэд олгосон газрын талбайн хэмжээг Засаг захиргааны нэгжээр харуулсан байдал.

Тайлант оны байдлаар нийт нутаг дэвсгэрийн 2 хувийг иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгоод байна.


Хүснэгт 2.3.1. Иргэн, хуулийн этгээдэд олгосон газрын талбайн хэмжээг газрын нэгдмэл сангийн ангиллаар харуулсан байдал

Газрын нэгдмэл сангийн ангилал		Талбайн хэмжээ /га/
Хөдөө аж ахуйн газар	<b>Бүгд</b>	<b>1290662.19</b>
	Бэлчээр	-
	Хадлан	7286.73
	Усалгаатай тариалан	334668.83
	Усалгаагүй тариалан	844897.10
	Атаршсан газар	108.02
	ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар	103671.50
	Ашиглахад тохиромжгүй газар	30.00
Хот тосгон, бусад суурины газар	<b>Бүгд</b>	<b>1602330.65</b>
	Барилга, байгууламжийн газар	1105339.73
	Суурьшлын газар	97008.12
	Үйлдвэрийн газар	21380.35
	Нийтийн эдэлбэрийн газар	5617.30
	Амралт, аялал жуулчлалын газар	16281.15
	Уурхайн газар	356047.72
	Хот суурин доторх бүх төрлийн зам, тэдгээрийн барилга байгууламжийн газар	656.27
	Хот суурин доторх инженерийн дэд бүтцийн зориулалтын газар	0.00
Цаашид тэлж хөгжих нөөц газар	0.00	

Зам, шугам сүлжээний газар	<b>Бүгд</b>	<b>74070.42</b>
	Төмөр замын газар	23875.09
	Авто замын газар	9818.03
	Агаарын тээврийн газар	5982.25
	Шугам сүлжээний газар	34374.82
	Усан тээврийн газар	20.24
Ойн сан бүхий газар	<b>Бүгд</b>	<b>91748.47</b>
	Ойн сан бүхий газар	91748.47
	Ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй газар	0.00
Усны сан бүхий газар	<b>Бүгд</b>	<b>13.87</b>
	Усны сан бүхий газар	0.00
	Булаг, шанд	0.00
	Нуур, цөөрөм, тойром	13.87
	Мөнх цас, мөсөн гол	0.00
	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс	0.00
<b>Нийт дүн</b>		<b>3058825.59</b>


## 2.4. ГАЗРЫН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАЙЛАН /МАЯГТ ГНСТ-6/

Улсын хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 1233706 нэгж талбарыг иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон байна. Үүнээс 626066 нэгж талбарыг өмчилж, 599845 нэгж талбарыг эзэмшиж, 17882 нэгж талбарыг ашиглаж байна.




Зураг 2.4.1. Өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгосогдсон нэгж талбарыг хувиар харуулсан байдал.

Улсын хэмжээнд иргэн, хуулийн этгээдэд олгосон газрыг эрхийн төрлөөр нь ангилбал Монгол Улсын иргэнд 626066 нэгж талбарыг газар өмчлөх эрхтэйгээр, Монгол Улсын иргэнд 546998, аж ахуйн нэгжид 34965, төрийн байгууллагад 17882 нэгж талбаруудыг тус тус газар эзэмших эрхтэйгээр, Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд 5583, гадаадын хуулийн этгээдэд 30, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид 2087, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд 95 нэгж талбаруудыг газар ашиглах эрхтэйгээр тус тус олгоод байна.



Зураг 2.4.2. Иргэн, хуулийн этгээдэд олгосон нэгж талбарын тоо




Зураг 2.4.2. Иргэн, хуулийн этгээдэд олгосон нэгж талбарын тоог засаг захиргааны нэгжээр харуулсан байдал.

Хүснэгт 2.4.1. Иргэн, хуулийн этгээдэд олгосон газрын талбайн хэмжээг газрын нэгдмэл сангийн ангиллаар харуулсан байдал

Газрын нэгдмэл сангийн ангилал		Нэгж талбарын тоо
Хөдөө аж ахуйн газар	<b>Бүгд</b>	<b>165885</b>
	Бэлчээр	0
	Хадлан	1347
	Усалгаатай тариалан	20087
	Усалгаагүй тариалан	18260
	Атаршсан газар	18
	ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар	126171
	Ашиглахад тохиромжгүй газар	2
Хот тосгон, бусад суурины газар	<b>Бүгд</b>	<b>1060610</b>
	Барилга, байгууламжийн газар	53129
	Суурьшлын газар	992517
	Үйлдвэрийн газар	5456
	Нийтийн эдэлбэрийн газар	1693
	Амралт, аялал жуулчлалын газар	6108
	Уурхайн газар	1695
	Хот суурин доторх бүх төрлийн зам, тэдгээрийн барилга байгууламжийн газар	12
	Хот суурин доторх инженерийн дэд бүтцийн зориулалтын газар	0
	Цаашид тэлж хөгжих нөөц газар	0
Зам, шугам сүлжээний газар	<b>Бүгд</b>	<b>4864</b>
	Төмөр замын газар	206
	Авто замын газар	392
	Агаарын тээврийн газар	106
	Шугам сүлжээний газар	4147
	Усан тээврийн газар	13
Ойн сан бүхий газар	<b>Бүгд</b>	<b>2340</b>
	Ойн сан бүхий газар	2340
	Ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй газар	0
Усны сан бүхий газар	<b>Бүгд</b>	<b>7</b>
	Усны сан бүхий газар	0
	Булаг, шанд	0
	Нуур, цөөрөм, тойром	7
	Мөнх цас, мөсөн гол	0
	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс	0
<b>Нийт дүн</b>		<b>1233706</b>

## 2.5.ГАЗАР ӨМЧЛӨЛИЙН ТАЙЛАН /МАЯГТ ГНСТ-7/

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу 2023 оны жилийн эцсийн байдлаар Улсын хэмжээнд өссөн дүнгээр нийт **723515** иргэний **71** мянган га газрын өмчлөх эрхийг баталгаажуулсан байна.



Зураг 2.5.1. 2003-2023 онуудын газар өмчлөлийн байдлыг иргэдийн тоотой харьцуулсан байдал

Хүснэгт 2.5.1. Хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи газар өмчлөлийн байдал

№	Он	МУ-ын нийт хүн амын тоо	Газар өмчилсэн нийт иргэдийн тоо	Хувь
1	2003	2495091	21879	0.9
2	2004	2521733	63867	2.5
3	2005	2551081	135077	5.3
4	2006	2583254	152164	5.9
5	2007	2620446	174016	6.6
6	2008	2665955	222094	8.3
7	2009	2716275	203043	7.5
8	2010	2760968	255749	9.3
9	2011	2811666	255747	9.1
10	2012	2867744	330240	11.5
11	2013	2930277	371978	12.7
12	2014	2995949	418671	14.0
13	2015	3057778	446004	14.6
14	2016	3119935	537321	17.2
15	2017	3119935	570771	18.3
16	2018	3177899	615454	19.4
17	2019	3238479	637501	19.7
18	2020	3296866	647664	19.6
19	2021	3357542	663145	19.8
20	2022	3409939	680797	20.0
21	2023	3457548	723515	20.6

Тайлбар: 2023 оны эцсийн байдлаар Монгол Улсын хүн амын тоо аймаг, нийслэлийн хэмжээнд нэгтгэгдэж, албан ёсоор гараагүй тул өмнөх /2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр / тоон мэдээг ашигласан болно.

Монгол Улсын нийт хүн амын тоотой газар өмчилсөн иргэдийн тоог харьцуулахад 20.6 хувь байх бөгөөд өмнөх оны хувьтай харьцуулахад 0.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гэр бүлийн хэрэгцээнд нэг удаа үнэ төлбөргүй өмчилсөн 70.5 мянган га газрыг 707500 иргэнд, аж ахуйн зориулалтаар давуу эрхээр худалдаж 390.44 га газрыг 4713 иргэнд, аж ахуйн зориулалтаар дуудлага худалдаагаар 124.08 га газрыг 343 иргэнд, газар тариалангийн зориулалтаар давуу эрхээр худалдаж 25.61 га газрыг 42 иргэнд худалдаж тус тус өмчлүүлээд байна.

Улсын хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэ төлбөргүй газар өмчилсөн иргэдийн тоог засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр харьцуулж, хүснэгт 2.8.2-т үзүүлэв.

*Хүснэгт 2.5.2. Үнэгүй газар өмчилж авсан иргэдийг хүн амын тоотой харьцуулсан байдал*

№	Аймаг	Хүн амын тоо	Өмчилсөн иргэдийн тоо	Хүн амын газар өмчилсөн байдал /хувиар/
1	Архангай	93149	13142	14.1
2	Баян-Өлгий	114776	13955	12.2
3	Баянхонгор	88397	12091	13.7
4	Булган	61161	17125	28.0
5	Говь-Алтай	57098	8075	14.1
6	Говьсүмбэр	18007	10132	56.3
7	Дархан-Уул	107932	16093	14.9
8	Дорноговь	71129	21350	30.0
9	Дорнод	83704	35882	42.9
10	Дундговь	46387	18593	40.1
11	Завхан	71798	9880	13.8
12	Орхон	109125	21381	19.6
13	Өвөрхангай	114962	35336	30.7
14	Өмнөговь	72937	43335	59.4
15	Сүхбаатар	65214	11787	18.1
16	Сэлэнгэ	107341	51539	48.0
17	Төв	92038	78112	84.9
18	Увс	83964	11241	13.4
19	Ховд	91071	13551	14.9
20	Хөвсгөл	136633	15339	11.2
21	Хэнтий	78959	26092	33.0
22	Улаанбаатар	1691766	234504	13.9
<b>Улсын дүн</b>		<b>3457548</b>	<b>723515</b>	<b>20.6</b>

Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэ төлбөргүй газар өмчилсөн иргэдийн тоог аймгийн хүн амын тоотой харьцуулахад Төв аймаг 84.9, Өмнөговь аймаг 59.4, Говьсүмбэр аймаг 56.3 хувиар хамгийн их хувьтай байгаа бол хамгийн бага хувьтай нь Хөвсгөл аймаг 11.2 байна.

Харин Архангай, Баян-Өлгий, Дорнод, Өмнөговь аймгууд нь өмнөх оныхоос буурсан үзүүлэлттэй байна.



## 2.6. ГАЗРЫН ТӨЛБӨР НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТИЙН ТАЙЛАН /ГНСТ-8/

Газрын тухай хуулийн дагуу Монгол Улсын иргэн, хуулийн этгээд болон гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлбөрийг Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу улсын хэмжээнд ногдуулж, орлогыг бүрдүүлдэг бөгөөд 2023 онд Татварын ерөнхий газартай хамтарсан дундын мэдээллийн сангаар дамжуулан Засгийн газрын 2018 оны “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 182 дугаар тогтоол, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2022 оны “Газрын төлбөр ногдуулах аргачилсан заавар” 209 дугаар тушаал, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Татварын ерөнхий газартай хамтарсан 2019 оны 173/178 тоот “Мэдээлэл солилцох журам”, “Мэдээлэл харилцан солилцох тухай гэрээ” 2019/09-01/32 дугаар гэрээний дагуу газрын төлбөрийг дундын мэдээллийн сангаар дамжуулан ногдуулж, төвлөрүүлж байна.


Газрын төлбөрийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш газрын төлбөрийн орлогоос 1 их наяд 178 тэрбум 897 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөснөөс өссөн дүнгээр нийт 1 их наяд 97 тэрбум 269 сая төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд 1998 онтой харьцуулж үзэхэд 2023 оны газрын төлбөрийн орлого 92.2 дахин нэмэгдсэн байдалтай байна /Хүснэгт 2.6.1/.

Хүснэгт 2.6.1. Газрын төлбөрийн гүйцэтгэл /он тус бүрээр/

Он	Газрын төлбөрийн төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл / сая.төг/	Гүйцэтгэл /%/
1998	1,919.6	1,524.5	80
1999	2,678.6	1,764.2	66
2000	3,221.5	2,895.0	90
2001	4,673.6	5,401.9	116
2002	5,570.7	6,163.1	110
2003	7,303.4	7,962.0	109
2004	1,1840	11,795.2	99
2005	13,867.6	14,045.2	101
2006	14,323.0	15,780.7	110
2007	19,786.8	20,093.7	102
2008	24,790.4	25,543.4	102
2009	28,006.6	29,472.4	105
2010	29,311.7	30,448.6	104
2011	31,280.7	33,556.8	107
2012	39,031.3	43,623.2	112
2013	37,912.0	43,185.1	114
2014	42,326.9	44,950.9	106
2015	45,712.6	44,556.2	97
2016	47,002.6	46,940.4	99.9
2017	47,683.4	49,361.9	103.5
2018	48,875.9	51,616.9	105.6
2019	76,426.8	88,070.9	115.2
2020	125,070.0	107,413.3	86.4
2021	158,960.0	112,691.3	70.9
2022	154,322.0	117,924.2	76.4
2023	156,325.4	140,488.6	90.0

Нийт	1,178,897.7	1,097,269.60	93.0
------	-------------	--------------	------

Улсын хэмжээнд 2023 оны газрын төлбөрийн орлогоос орон нутгийн төсөвт 156 тэрбум 325 сая төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс 179 тэрбум 690 сая төгрөгийн ногдуулалт хийж нийт 140 тэрбум 488 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 90 хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн байна /Хүснэгт 2.6.2, Зураг 2.6.1/.




Зураг 2.6.1. Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /он тус бүрээр/

Газрын төлбөрийн 2023 оны батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг аймаг, нийслэл тус бүрээр авч үзэхэд Баян-Өлгий, Говь-Алтай, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг аймгууд 100-аас дээш хувийн гүйцэтгэлтэйгээр төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна /Хүснэгт 2.6.2, Зураг 2.6.2/.

Хүснэгт 2.6.2. Аймаг, нийслэлийн 2023 оны газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөний биелэлт

№	Аймаг, нийслэл	Төлөвлөгөө (мян.төг)	Гүйцэтгэл (мян.төг)	Гүйцэтгэл (Хувь)
1	Архангай	272,041.6	155,638.1	57
2	Баянхонгор	879,720.0	761,966.2	87
3	Баян-Өлгий	267,200.0	287,145.4	107
4	Булган	1,515,331.7	1,241,416.7	82
5	Говь-Алтай	594,837.1	698,908.7	117
6	Говьсүмбэр	499,900.0	316,259.2	63
7	Дархан-Уул	1,814,764.8	1,553,538.7	86
8	Дорнод	3,260,000.0	2,181,956.8	67
9	Дорноговь	5,766,095.0	4,956,183.8	86
10	Дундговь	556,753.4	1,303,575.3	234
11	Завхан	163,000.0	729,121.9	447
12	Орхон	26,515,000.0	29,419,387.4	111
13	Өвөрхангай	775,999.9	829,687.1	107
14	Өмнөговь	12,320,520.9	13,224,858.8	107
15	Сүхбаатар	518,808.8	592,095.3	114
16	Сэлэнгэ	1,799,999.9	1,738,062.3	97
17	Төв	3,667,990.0	2,677,308.5	73
18	Увс	700,000.0	468,720.0	67
19	Ховд	742,332.4	776,550.2	105
20	Хөвсгөл	475,832.5	593,501.0	125

21	Хэнтий	973,500.0	1,073,288.3	110
22	Улаанбаатар	92,245,803.9	74,909,434.2	81
ДҮН		<b>156,325,432.0</b>	<b>140,488,603.9</b>	<b>90</b>



Зураг 2.6.2. Тайлант оны газрын төлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэл, хувь


2019 онд Газрын төлбөр, татварын цахим системийг хэрэглээнд нэвтрүүлж, Татварын ерөнхий газартай хамтарсан дундын мэдээллийн сангаар дамжуулан газрын төлбөрийн нэхэмжлэлийг иргэн, хуулийн этгээдэд илгээдэг болсноор цахим систем /egazar.gov.mn, ebarimt/, бүх банкны интернэт банк болон гар утасны аппликэйшн ашиглан түргэн шуурхай газрын төлбөрийн мэдээлэл авах, нэхэмжлэхээр төлбөрөө төлөх боломжийг бүрдүүлснээр газрын төлбөрийн орлого төвлөрүүлэлт тогтмол нэмэгдэж байна /Зураг 2.6.3/.



Зураг 2.6.3. Газрын төлбөрийн орлого /1998-2023 он/

Тайлант оны газрын төлбөрийн орлогыг өмнөх онтой харьцуулахад 22 тэрбум 576 сая төгрөгөөр өссөн дүнтэй байгаа нь Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд суурилсан Газрын төлбөр, татварын системээр эрхзүйн харилцаа үүссэн бүртгэлтэй нэгж талбар бүрт ногдуулалт хийж Татварын системд илгээсэн бөгөөд цаашид уул уурхайн ашиглалтын лиценз бүхий газар, улсын тусгай

хамгаалалттай газарт олгогдсон газруудыг тус системд бүрэн бүртгэж баталгаажуулснаар газрын төлбөрийн орлого өсөж цаашид нэмэгдэх хандлагатай байна.



Зураг 2.6.4. Тайлант оны газрын төлбөрийн орлогын гүйцэтгэл /хувиар/

Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн аймгийн хувьд хууль тогтоомжийн дагуу газрын төлбөрийг газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэгж талбар бүрт ногдуулж, хураан барагдуулах ажлыг батлагдсан журам, зааврын дагуу хэрэгжүүлэн ажилласан байна.

2023 онд газрын төлбөрөөс орон нутгийн төсөвт оруулсан орлогыг газрын нэгдмэл сангийн ангиллаар авч үзвэл хамгийн их хувийг хот тосгон, бусад суурины газар болон тусгай хэрэгцээний газар бөгөөд хамгийн бага хувийг усны сан бүхий газар, зам, шугам сүлжээний газрын төлбөр эзэлж байна. Энэ нь хот суурин газрын эрх зүйн харилцаа үүссэн нэгж талбарын тоо бусад ангиллын эрх зүйн харилцаа үүссэн нэгж талбарын тооноос харьцангуй их байгаатай холбоотой юм /Хүснэгт 2.6.3/.

Хүснэгт 2.6.3. Газрын төлбөрийн орлого төвлөрүүлэлт /газрын нэгдмэл сангийн ангиллаар/

№	Аймаг, нийслэл	Газрын нэгдмэл сангийн ангилал					
		Хөдөө аж ахуйн эдэлбэр газар /мян.төгрөг/	Хот, тосгон, бусад суурины газар /мян.төгрөг/	Ойн сан бүхий газар /мян.төгрөг/	Усны сан бүхий газар /мян.төгрөг/	Зам шугам сүлжээний газар /мян.төгрөг/	Тусгай хэрэгцээний газар /мян.төгрөг/
1	Архангай	29,717.7	107,493.3	-	-	3,403.1	15,024.0
2	Баянхонгор	40,256.9	711,809.4	6,218.8	-	-	3,681.1
3	Баян-Өлгий	8,572.8	269,876.3	-	-	646.3	8,050.0
4	Булган	193,125.9	941,491.4	51,213.9	14.2	13,667.1	41,904.2
5	Говь-Алтай	65,012.8	600,772.3	-	19,910.9	3,718.1	9,494.5
6	Говьсүмбэр	1,985.9	306,980.8	-	-	7,126.9	165.7
7	Дархан-Уул	72,950.8	1,372,266.0	10,103.3	-	63,573.2	34,645.4
8	Дорнод	210,260.9	1,953,677.3	-	-	-	18,018.6
9	Дорноговь	327,353.0	4,512,163.3	-	-	114,543.5	2,124.0
10	Дундговь	40,805.5	1,143,757.1	1,252.1	-	111,102.2	6,658.5
11	Завхан	48,972.0	625,457.6	3,264.9	-	33,061.1	18,366.4
12	Орхон	63,575.8	29,199,640.6	36,533.9	-	119,637.2	-
13	Өвөрхангай	48,803.2	654,388.5	-	-	95,053.3	31,442.1
14	Өмнөговь	52,669.6	12,466,755.2	103,338.6	-	438,072.9	164,022.4
15	Сүхбаатар	83,194.6	501,576.0	1,351.1	-	-	5,973.6
16	Сэлэнгэ	327,044.5	1,400,432.0	5,515.5	1,745.0	3,121.4	199.8
17	Төв	464,913.7	2,121,707.0	11,524.9	30.0	60,492.9	18,640.0
18	Увс	103,593.5	332,903.1	4,142.9	-	-	28,080.6
19	Ховд	57,197.6	659,355.0	54,078.8	3,600.0	2,318.8	-

20	Хөвсгөл	76,360.8	342,288.0	86.0	17.1	3,824.1	170,925.0
21	Хэнтий	572,769.5	500,518.8	-	-	-	-
22	Улаанбаатар	685,763.5	46,558,603.3	247,722.6	-	703,070.0	26,714,274.6
<b>Дүн</b>		<b>3,574,900.5</b>	<b>107,283,912.3</b>	<b>536,347.3</b>	<b>25,317.2</b>	<b>1,776,431.9</b>	<b>27,291,690.6</b>
<b>Хувь</b>		<b>2.5</b>	<b>76.3</b>	<b>0.4</b>	<b>0.1</b>	<b>1.3</b>	<b>19.4</b>

Газрын нэгдмэл сангийн ангиллаар авч үзэхэд хөдөө аж ахуйн эдэлбэр газар 3 тэрбум 574 сая төгрөг, хот, тосгон, бусад суурины газар 107 тэрбум 283 сая төгрөг, ойн сан бүхий газар 536 сая төгрөг, усны сан бүхий газар 25 сая төгрөг, зам шугам сүлжээний газар 1 тэрбум 776 сая төгрөг, тусгай хэрэгцээний газар 27 тэрбум 291 сая төгрөг тус тус газрын төлбөрийн орлогоос орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

Газрын төлбөрийн орлогоос орон нутгийн төсөвт төвлөрөх орлогын голлох хувийг Хот, тосгон, бусад суурины газар, улсын тусгай хамгаалалттай газар, уул уурхайн газар, хөдөө аж ахуйн эдэлбэр газрууд төлбөрийн орлого бүрдүүлж байна.

Газрын төлбөрийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ:

Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор хот тосгон бусад суурин газрын төлбөрийн итгэлцүүрийн тоон утга, бүсийн хил заагийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар “Газрын үнэлгээ зэрэглэл /бүс/-ийн зааг хязгаар, газрын төлбөрийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолыг батлуулж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Шинэчлэн батлагдсан тогтоолын дагуу Газрын төлбөр, татварын цахим системд бүртгэн баталгаажуулж газрын төлбөрийг шинэчлэн бодуулж 2023 оны газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэлийг цахимаар иргэн хуулийн этгээдэд хүргүүлсэн.

Газрын төлбөр, татварын системээр дамжуулан Татварын удирдлагын системд ногдуулалт илгээж байгаатай холбоотойгоор сум, дүүрэг тус бүрийн газрын төлбөрийг тодорхой гаргаж, төлбөрийг нэгж талбар тус бүрээр ногдуулж барагдуулах, газар эзэмшигчийн газрын төлбөрийн давхардлыг арилгах, алдааг засварлах, хянах, зорилгоор 7 хоног бүр ногдуулалт, нэхэмжлэх үүсгэх ажлын явцыг танилцуулж харилцан мэдээлэл солилцож, ажлын уялдааг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Татварын алба нь урьд оны дутуу төлөлт, газрын төлбөрийг барагдуулах төлбөрийн гүйцэтгэлийг хангахын тулд тухайн Газрын албанд урьд оны газрын төлбөрөөр тооцоо нийлэн нэхэмжлэх үүсгэж өгөх ба барагдуулах ажлыг хамтран зохион байгуулж ажиллаж байна.

Ингэснээр гар утас, цахим хаяг /e-mail/, и-баримт зэргээр газрын төлбөр төлөгч бүрд нэхэмжлэхийг шуурхай хүргэж газрын төлбөр төлөгчийг мэдээллээр хангаж ажиллаж байна.

*21 аймаг, нийслэлийн хэмжээнд Газрын татвар, төлбөрийн системээр дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан. Үүнд:*


- 2023 онд Газрын татвар, төлбөрийн системээр дамжуулан Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд бүртгэлтэй нэгж талбар тус бүрд төлбөр ногдуулах, татварын удирдлагын системд илгээх ажлыг зохион байгуулах;

- Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсантай холбоотойгоор мөн Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт орсны дагуу 330 сум, 9 дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх хил зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утгыг шинэчлэн батлуулах ажлыг зохион байгуулах;
- Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан тогтоолыг системд баталгаажуулж, газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх хил зааг, итгэлцүүрийг газар ашиглалтын зориулалт тус бүрээр оруулж баталгаажуулан газрын төлбөрийг шинэчлэн бодуулж, ногдуулалт, нэхэмжлэлийг үүсгэх;
- Үйлчилгээний хураамж, үнэт цаасны орлогыг Татварын удирдлагын систем болон Газрын төлбөр, татварын системээр төлбөрийн даалгавар үүсгэн, төлөх боломжийг хангах;
- Ашигт малтмал, газрын тосны газартай хамтран дундын мэдээллийн санг байгуулж ашиглалтын лиценз бүхий газруудыг Газрын кадастрын мэдээллийн санд бүрэн бүртгэж баталгаажуулж түүнд төлбөр ногдуулах;
- Газрын татвар, төлбөрийн урьд оны илүү, дутуу аймаг тус бүр нийт дүнгээр үүсгэсэн нэхэмжлэхийн төлөлтийг барагдуулж дуусгах;
- Иргэн хуулийн этгээдийн газрын төлбөрийн тооцоо нийлсэн актыг цахимаар авах хүсэлтийг баталгаажуулан шийдвэрлэж цахим хариуг илгээх;

Ингэснээр иргэн, хуулийн этгээд нь газартай холбоотой ямар нэгэн эрхзүйн харилцаанд ороход тухайн жил /улирал/-д газрын төлбөрийн үлдэгдэлгүй байх шаардлагатай тул цахимаар тус лавлагааг авснаар цаг хугацаа хэмнэх, түргэн шуурхай гэх мэт давуу талууд үүсэх чухал ач холбогдолтой юм.

## **2.7.ГАЗАРТ УЧРУУЛСАН ХОХИРЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГНСТ-9/**

Улсын хэмжээнд 2023 онд нийт 8,344,269.1 га газарт хохирол учруулсан дүн гарсан бөгөөд тариалангийн газрын 82,774.5 га, бэлчээрийн газрын 8,115,677.6 га, хот, тосгон, бусад суурины газрын 17,570 га, зам, шугам сүлжээний газрын 16,874.9 га, ойн сан бүхий газрын 110,930.6 га, усны сан бүхий газрын 441.5 га газарт тус тус хохирол учруулсан байна.



Зураг 2.7.1. Газарт учруулсан хохирлын талбайн хэмжээ, га /2022, 2023 он/.

Хүснэгт 2.7.1. Газарт учруулсан хохирол

№	Аймаг, Нийслэлийн нэр	Аймаг, Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээ /га/	Газарт учруулсан хохирлын талбай /га/	Газарт учруулсан хохирлын талбай аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд эзлэх %/
1	Архангай	5,531,382	94,734.8	1.7
2	Баян-Өлгий	4,570,589	513.5	0.0
3	Баянхонгор	11,597,680	30,824.7	0.3
4	Булган	4,873,300	249,137.3	5.1
5	Говь-Алтай	14,144,767	13,577.3	0.1
6	Говьсүмбэр	554,180	16,851.5	3.0
7	Дархан-Уул	327,500	1,770.5	0.5
8	Дорноговь	10,947,230	1,702.5	0.0
9	Дорнод	12,359,743	3,109,357.2	25.2
10	Дундговь	7,469,032	998,827.2	13.4
11	Завхан	8,245,566	191,447.8	2.3
12	Орхон	84,400	8,402.8	10.0
13	Өвөрхангай	6,289,533	440,361.7	7.0
14	Өмнөговь	16,538,047	4,271.6	0.0
15	Сүхбаатар	8,228,715	111,598.2	1.4
16	Сэлэнгэ	4,115,263	85,721.8	2.1
17	Төв	7,404,237	252,760.3	3.4
18	Увс	6,958,539	77,045.1	1.1
19	Ховд	7,606,038	5,197.9	0.1
20	Хөвсгөл	10,062,882	159,552.5	1.6
21	Хэнтий	8,032,506	2,454,724.6	30.6
22	Улаанбаатар	470,444	35,888	7.6
<b>Нийт</b>		<b>156,411,575</b>	<b>8,344,269.68</b>	<b>5.3</b>


### 2.7.1. Тариалангийн газар

Тариалангийн газрын хохирлын тайланг салхи, усны элэгдэл эвдрэлд орсон, үржил шим буурсан, хортон шавжид нэрвэгдсэн, хөрс бохирдсон, химийн бодисоор бохирдсон, хог ургамалд нэрвэгдсэн, хаягдсан гэсэн 8 үзүүлэлтээр тогтоодог.

Улсын хэмжээнд 82,774.5 га тариалангийн газарт хохирол учруулсан дүн гарсан ба нийт хохирол учруулсан талбайн 0.9 %-ийг эзэлж байна. Энэ дүн нь 2022 оныхоос 1,324.3 га талбайгаар их байна.

Тариалангийн газарт мэрэгчид болон хортон шавжийн нөлөөллөөр 48,858.5 га (59%) талбайд хамгийн их хохирол учруулсан байна.

Бусад хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл үржил шим буурсан 24,066.3 га (29%), химийн бодисоор бохирдсон 7,542.1 га (9%), усны эвдрэлд орсон 894.1 га (1%), салхины эвдрэлд орсон 717 га (0.8%), чулуужилт, давсжилт, намагжилтад орсноос хаягдсан 467.1 га (0.5%), хог ургамалд нэрвэгдсэн 229.4 га талбай (0.2%) байна (Зураг 2.7.1.1).



Зураг 2.7.1.1. Тариалангийн газарт учруулсан хохирлын төрөл, хувиар.


### 2.7.2. Бэлчээрийн газар

Бэлчээрийн газрын хохирлын тайланг талхлагдсан, салхи, усны эвдрэлд орсон, намагжсан, элсний нүүлтэд орсон, мэрэгчид, хортон шавжид талхлагдсан, цөлжсөн, ашигт малтмалын олборлолтод өртсөн, газрын тосны олборлолтоос бохирдсон, түймэрт өртсөн гэсэн 9 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд 8,115,677.6 га бэлчээрийн газарт хохирол учруулсан дүн гарсан ба нийт хохирол учруулсан талбайн 97.3 %-ийг эзэлж байна. Энэ нь 2022 оныхоос 3,434,174.62 га талбайгаар их байна.

Бэлчээрийн газрын 3,195,177.4 га (39%) талбай түймэрт өртсөн бөгөөд энэ нь бэлчээрийн газарт хамгийн их хохирол учруулсан хүчин зүйл болсон байна. Бусад хохирол учруулсан хүчин зүйлсийг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл талхлагдсан 3,078,187.6 га (37.9%), мэрэгчид, хортон шавжид идэгдсэн 1,770,246.1 га (21.8%), элсний нүүлтэд орсон 65,076.9 га (0.8%), ашигт малтмалын олборлолтод өртсөн 3,397.0 га (0.04%), салхи, усны эвдрэлд орсон 2316.5 га (0.03%), цөлжсөн 1274.0 га (0.02%) байна (Зураг 2.7.2.1.).






Зураг 2.7.2.1. Бэлчээрт учруулсан хохирлын төрөл, хувиар.

### 2.7.3. Хот, тосгон, бусад суурины газар

Хот, тосгон, бусад суурины газрын хохирлын тайланг ургамлан бүрхэвчгүй болсон, элсний нүүлтэд орсон, химийн болон цацраг идэвхт бодисоор хордсон, үйлдвэрийн хог хаягдлаар бохирдсон, ахуйн хог хаягдлаар бохирдсон, шатах тослох материал болон хүнд металлаар бохирдсон, ашигт малтмалын олборлолтоос болон ухагдаж эвдэрсэн гэсэн 7 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд 17,570.46 га хот, тосгон, бусад суурины газарт хохирол учруулсан ба энэ нь нийт хохирол учруулсан талбайн 0.2 %-ийг эзэлж байна. Энэ нь 2022 оныхоос 7,049.66 га талбайгаар нэмэгдсэн байна.

Хот, тосгон, бусад суурины газрын 16,062.7 га (91.4%) талбай ахуйн хог хаягдлаар бохирдсон байна. Бусад хохирол учруулсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл ашигт малтмалын олборлолтоос болон ухагдаж эвдэрсэн 805.8 га (4.6%), элсний нүүлтэд орсон 471.1 га (2.7%), шатах тослох материал болон хүнд металлаар бохирдсон 170.8 га (1.0%), ургамлан бүрхэвчгүй болсон 37.2 га (0.2%), үйлдвэрийн хог хаягдлаар бохирдсон 22.8 га (0.1%) байна /Зураг 2.7.3.1/.



Зураг 2.7.3.1. Хот, тосгон, бусад суурины газарт учруулсан хохирлын төрөл, хувиар.

#### 2.7.4. Зам, шугам сүлжээний газар

Зам, шугам сүлжээний газрын хохирлын тайланг цахилгаан эрчим хүч, барилга засвар, зам тээвэр, холбоо үйлчилгээний ажлаас бохирдсон, зам, шугам сүлжээний ажлаас шалтгаалан ухагдаж эвдэрсэн, байгалийн гамшиг болон үерийн улмаас нуранги, гуу жалга үүссэн, хий дамжуулах хоолой, барилга байгууламж барих ажлаас үүссэн гэсэн 4 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд 16,874.9 га зам, шугам сүлжээний газарт хохирол учруулсан нь хохирол учруулсан нийт талбайн 0.2 %-ийг эзэлж байна.

Зам, шугам сүлжээний газрын хамгийн их хохирол учруулсан талбайд байгалийн гамшиг болон үерийн улмаас нуранги, гуу жалга үүссэн талбай 13,804 га (81.8%), зам, шугам сүлжээний ажлаас шалтгаалан ухагдаж эвдэрсэн 3,069.9 га (18.2%), цахилгаан эрчим хүч, барилга засвар, зам тээвэр, холбоо үйлчилгээний ажлаас бохирдсон 1.1 га (0.01%) байна /Зураг 2.7.4.1/.



Зураг 2.7.4.1. Зам, шугам сүлжээний газарт учруулсан хохирлын төрөл, хувиар.

#### 2.7.5. Ойн сан бүхий газар

Ойн сан бүхий газрын хохирлын тайланг түймэрт нэрвэгдсэн, өвчин, хортон шавжид идэгдсэн, мод бут, сөөг, загийг устгасан, мод бэлтгэл, огтлолт, боловсруулалтаас, ашигт малтмалын олборлолтод өртсөн гэсэн 5 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд 110,930.6 га ойн сан бүхий газарт хохирол учруулсан нь нийт хохирол учруулсан талбайн 1.33 %-ийг эзэлж байна. Энэ нь 2022 оныхоос 54,098.02 га талбайгаар их байна.

Ойн сан бүхий газарт хамгийн их хохирол учруулсан хүчин зүйлийг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл өвчин, хортон шавжид идэгдсэн 93,517.5 га (84.3%), түймэрт нэрвэгдсэн 8,278.8 га (7.5%), ашигт малтмалын олборлолтод өртсөн 3,752 га (3.4%), мод бэлтгэл, огтлолт, боловсруулалт 3,511.6 га (3.2%), мод бут, сөөг, загийг устгасан 1'870,7 га (1.7%) байна /Зураг 2.7.5.1/.




Зураг 2.7.5.1. Ойн сан бүхий газарт учруулсан хохирлын төрөл, хувиар.

### 2.7.6. Усны сан бүхий газар

Усны сан бүхий газрын хохирлын тайланг гадаргын болон гүний ус бохирдсон, үйлдвэрийн хордолт, бохирдолтод өртсөн эрэг хавийн газар, ашигт малтмалын олборлолтоос эвдрэлд өртсөн эрэг хавийн газар, мал болон хүний үйл ажиллагаанаас булаг шанд, худаг ойр орчмын газар бохирдсон гэсэн 4 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд 4,415 га усны сан бүхий газарт хохирол учруулсан ба хохирол учруулсан нийт талбайн 0.01 %-ийг эзэлж байна. Энэ нь 2022 оныхоос 246 га талбайгаар их байна.

Усны сан бүхий газрын хамгийн их хохирол учруулсан талбайд гадаргын болон гүний ус бохирдсон 203 га (46%), мал болон хүний үйл ажиллагаанаас булаг шанд, худаг ойр орчмын газар бохирдсон 167.5 га (38%), ашигт малтмалын олборлолтоос эвдрэлд өртсөн эрэг хавийн газар 71 га (16%) байна /Зураг 2.7.6.1/.




Зураг 2.7.6.1. Усан сан бүхий газарт учруулсан хохирлын төрөл, хувиар.

## 2.8. ГАЗАР ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН /МАЯГТ ГНСТ-10/

2023 онд улсын хэмжээнд нийт 3,895,754.16 га газарт хамгаалах, нөхөн сэргээсэн арга хэмжээг авсан бөгөөд тариалангийн газрын 205,924 га, бэлчээрийн газрын 3,540,136.29 га, хот, тосгон, бусад суурины газрын 23,275.3 га, уурхайн эдэлбэр газрын 1,790.5 га, зам, шугам сүлжээний газрын 55.74 га, ойн сан бүхий газрын 98,544.86 га, усны сан бүхий газрын 26,020 га, улсын тусгай хэрэгцээний 8 га газарт хамгаалах, нөхөн сэргээсэн арга хэмжээг тус тус авсан байна /Зураг 2.8.1/.

Энэ нь 2022 оны дүнгээс 2,349,271 га талбайгаар өссөн байна. Баянхонгор, Төв, Хэнтий, Өвөрхангай, Завхан, Булган аймгууд газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хамгийн их төлөвлөж хэрэгжүүлсэн байна.



Зураг 2.8.1. Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн талбай, га /2022, 2023 он/

Хүснэгт 2.8.1. Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн байдал

№	Аймаг, Нийслэлийн нэр	Аймаг, Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээ /га/	Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн талбай /га/	Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн талбай аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд эзлэх /%/
1	Архангай	5,531,382	47,859.8	0.9
2	Баян-Өлгий	4,570,589	49.1	0.0
3	Баянхонгор	11,597,680	1,534,355.7	13.2
4	Булган	4,873,300	204,319.7	4.2
5	Говь-Алтай	14,144,767	13,552.3	0.1
6	Говьсүмбэр	554,180	14,281.7	2.6
7	Дархан-Уул	327,500	517.6	0.2
8	Дорноговь	10,947,230	126,935.9	1.2
9	Дорнод	12,359,743	57,473.5	0.5
10	Дундговь	7,469,032	32,516.2	0.4


11	Завхан	8,245,566	364,036.0	4.4
12	Орхон	84,400	3,120.9	3.7
13	Өвөрхангай	6,289,533	369,511.5	5.9
14	Өмнөговь	16,538,047	4,419.7	0.0
15	Сүхбаатар	8,228,715	54,123.4	0.7
16	Сэлэнгэ	4,115,263	47,433.2	1.2
17	Төв	7,404,237	415,548.4	5.6
18	Увс	6,958,539	175,503.3	2.5
19	Ховд	7,606,038	7,692.7	0.1
20	Хөвсгөл	10,062,882	44,684.2	0.4
21	Хэнтий	8,032,506	377,760.7	4.7
22	Улаанбаатар	470,444	58.9	0.0
<b>Нийт</b>		<b>156,411,575</b>	<b>3,895,754.2</b>	<b>2.49</b>

### 2.8.1. Тариалангийн газар

Тариалангийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайланг олон наст ургамал тарьсан, зурваслан тариалсан, ойн зурвасаар хамгаалагдсан, химийн бордоогоор бордсон, шим ба эрдэс бордоогоор бордсон, хортон шавж, мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн, хүчтэй элэгдэж, эвдэрсэн тариалан болон атаршсан газрыг нөхөн сэргээсэн гэсэн 6 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд 205,924 га тариалангийн газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн нь нийт талбайн 5.3 %-ийг эзэлж байна. Энэ нь 2022 оныхоос 99,666 га талбайгаар их байна.

Тариалангийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн газрын ихэнх хэсгийг хортон шавж, мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн талбай 120,679.9 га (58.6%), шим ба эрдэс бордоогоор бордсон 49,655.9 га (24.1%), зурваслан тариалсан 23,357 га (11.3%), химийн бордоогоор бордсон талбай 6,746.2 га (3.3%), ойн зурвасаар хамгаалагдсан 4,577.4 га (2.2%), олон наст ургамал тарьсан 549.7 га (0.3%), хүчтэй элэгдэж, эвдэрсэн тариалан болон атаршсан газрыг нөхөн сэргээсэн 357 га (0.2%) байна /Зураг 2.8.1.1./.




Зураг 2.8.1.1. Тариалангийн газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн байдал, хувиар.

### 2.8.2. Бэлчээрийн газар

Бэлчээрийн газрыг хамгаалах, нөхөн сэргээсэн арга хэмжээний тайланг элсний нүүлтээс хамгаалсан, тордон сайжруулсан, хортон шавж, мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн, хог хаягдлаас цэвэрлэсэн, даацыг зохицуулсан, ашиглалтаас чөлөөлсөн, өнжөөсөн, сэлгэж ашигласан, бэлчээр усжуулсан гэсэн 8 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд 3,540,136.3 га бэлчээрийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн нь нийт талбайн 90.9%-ийг эзэлж байна. Энэ нь 2022 оныхоос 2,188,239.2 га талбайгаар их байна.

Бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн газрын дийлэнх хэсгийг өнжөөсөн, сэлгэж ашигласан 2,224,937 га (62.8%), хортон шавж, мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн талбай 736,403.7 га (21.6%), бэлчээр усжуулсан 20,241.8 га (0.6%), ашиглалтаас чөлөөлсөн 171,181 га (4.8%), хог хаягдлаас цэвэрлэсэн 144,320 га (4.1%), тордон сайжруулсан 17,412.4 га (0.5%), даацыг тохируулсан 16,400 га (0.5%), элсний нүүлтээс хамгаалсан 64.42 га (0.002%) талбай байна.



Зураг 2.8.2.1. Бэлчээрийн газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн байдал, хувиар.


### 2.8.3. Хот, тосгон, бусад суурины газар

Хот, тосгон, бусад суурины газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэнний тайланг хөрсжүүлж зүлэгжүүлсэн, мод бут сөөг тарьсан, далан хаалтаар хамгаалсан, нүх, гуу жалгыг тэгшилж янзалсан, ахуйн хог хаягдлаас цэвэрлэсэн, үйлдвэрийн хог хаягдлаас цэвэрлэсэн, элсний нүүлтээс хамгаалсан, химийн болон цацраг идэвхт бодисоос цэвэрлэсэн гэсэн 8 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд 23,275.3 га хот, тосгон, бусад суурины газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн нь нийт талбайн 0.6 %-ийг эзэлж байна. Энэ нь 2022 оныхоос 7,589.5 га талбайгаар их байна.

Хот, тосгон, бусад суурины газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн газрын дийлэнх хэсгийг ахуйн хог хаягдлыг цэвэрлэсэн талбай 22,048.5 га (94.7%), мод бут, сөөг тарьсан талбай 839.06 га (3.6%), нүх, гуу жалгыг тэгшилж янзалсан 47.11 га (0.2%), далан хаалтаар хамгаалсан 21.0 га (0.09%),

үйлдвэрийн хог хаягдлаас цэвэрлэсэн 6.44 га (0.03%), элсний нүүлтээс хамгаалсан 5.23 га (0.02%), хөрсжүүлж зүлэгжүүлсэн 2.41 га (0.01%) байна.




Зураг 2.8.3.1. Хот, тосгон, бусад суурины газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн байдал, хувиар.

#### 2.8.4. Уурхайн эдэлбэр газар

Уурхайн эдэлбэр газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсний тайланг ухагдаж, эвдэрсэн газрыг эргүүлэн дарж булсан, дарж булсан талбайг хөрсжүүлж, ургамалжуулсан биологийн нөхөн сэргээлт хийсэн, эвдрэлд өртсөн голын эрэг хавийн газрыг сэргээсэн, голын гольдролыг буцааж хэвэнд нь оруулсан гэсэн 3 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд 1,790.5 га уурхайн эдэлбэр газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн нь нийт талбайн 0.05%-ийг эзэлж байна. Энэ нь 2022 оныхоос 2,372 га талбайгаар бага байна.

Уурхайн эдэлбэр газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн газрын дийлэнх хэсгийг ухагдаж, эвдэрсэн газрыг эргүүлэн дарж булсан 1452.4 га (81.1%), дарж булсан талбайг хөрсжүүлж, ургамалжуулсан биологийн нөхөн сэргээлт хийсэн 306.8 га (17.1%), эвдрэлд өртсөн голын эрэг хавийн газрыг сэргээсэн, голын гольдролыг буцааж хэвэнд нь оруулсан 31.3 га (1.7%) байна. /Зураг 2.8.4.1/




*Зураг 2.8.4.1. Уурхайн эдэлбэр бүхий газрын хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн байдал, %.*

### 2.8.5. Зам, шугам сүлжээний газар

Зам, шугам сүлжээний газрыг хамгаалах, нөхөн сэргээсэн арга хэмжээ хэмжээний тайланг авто зам, төмөр зам, агаар, усан замын эвдэрсэн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн, цахилгаан эрчим хүч, болон харилцаа холбооны чиглэлээр болон бусад гэсэн үзүүлэлтүүдээр гаргадаг.

Улсын хэмжээнд 55.7 га зам, шугам сүлжээний газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн нь нийт талбайн 0.001 %-ийг эзэлж байна.

Зам, шугам сүлжээний газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн газрын дийлэнх хэсгийг цахилгаан эрчим хүч, болон харилцаа холбооны чиглэлээр 30.79 га (55.24%), авто зам, төмөр зам, агаар, усан замын эвдэрсэн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн 24.95 га (44.76%) байна /Зураг 2.8.5.1/.



*Зураг 2.8.5.1. Зам, шугам сүлжээний газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн байдал, %.*

### 2.8.6. Ойн сан бүхий газар

Ойн сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсний тайланг ойн цэвэрлэгээ хийсэн, өвчин хортон шавжтай тэмцэх арга хэмжээ авсан, мод бут сөөг шинээр тарьсан, нөхөн суулгалт хийсэн гэсэн 3 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд 98,544.8 га ойн сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн нь нийт талбайн 2.5 %-ийг эзэлж байна. Энэ нь 2022 оныхоос 42,771.6 га талбайгаар их байна.

Ойн сан бүхий газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн газрын дийлэнх хэсгийг өвчин, хортон шавжтай тэмцэх арга хэмжээ авсан талбай 93,182.6 га (94.5%), ойн цэвэрлэгээ хийсэн талбай 2,794.7 га (2.8%), мод, бут, сөөг, шинээр тарьсан, нөхөн суулгалт хийсэн талбай 2,567.4 га (2.6%)-ийг байна /Зураг 2.8.6.1/.





Зураг 2.8.6.1. Ойн сан бүхий газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн байдал, хувиар.

### 2.8.7. Усны сан бүхий газар

Усны сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсний тайланг ус, усан орчныг цэвэрлэх, цэвэршүүлэх арга хэмжээ авсан, усны эх булаг, эрэг орчмын газрын хөрсийг цэвэрлэх, хамгаалах арга хэмжээ авсан, усны үер, эвдрэлээс хамгаалах арга хэмжээ авсан гэсэн 3 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд 26,020 га усны сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн нь нийт талбайн 0.66 %-ийг эзэлж байна. Энэ нь 2022 оныхоос 11,178.7 га талбайгаар их байна.

Усны сан бүхий газарт хамгаалах, нөхөн сэргээсэн арга хэмжээ авсан газрын дийлэнх хэсгийг усны үер, эвдрэлээс хамгаалах арга хэмжээ авсан 13'653 га (52.4%), усны эх булаг, эрэг орчмын газрын хөрсийг цэвэрлэх, хамгаалах арга хэмжээ авсан 11584 га (44.5%), ус, усан орчныг цэвэрлэх, цэвэршүүлэх арга хэмжээ авсан талбай 783.1 га (3.0%) байна.



Зураг 2.8.7.1. Усны сан бүхий газарт хамгаалах, нөхөн сэргээсэн арга хэмжээ хэрэгжүүлсэн, хувиар.

### 2.8.8. Улсын тусгай хэрэгцээний газар

Улсын тусгай хэрэгцээний газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсний тайланг мод, зүлэг тарьж ногоон байгууламж бий болгосон, улсын тусгай хамгаалалттай газарт хэрэгжүүлсэн газар хамгаалах, нөхөн сэргээсэн арга хэмжээ, тэжээлийн ургамал, олон наст тариалсан, элэгдэж, эвдэрсэн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн, хог хаягдал дарж булшилсан, тэгшилсэн, хоргүйжүүлсэн гэсэн 5 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 8 га улсын тусгай хэрэгцээний газарт мод, зүлэг тарьж ногоон байгууламж бий болгосон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

## 3. ДҮГНЭЛТ

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар болгон өөрчилж, Монгол Улсын Ерөнхий Сайдын эрхлэх асуудлын хүрээнд байхаар “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны захирамжаар 93 орон тоогоор 3 газар, 10 нэгжтэйгээр бөцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн баталсан.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 79 дүгээр тогтоолыг үндэслэн Барилга, хот байгуулалтын яамны салбарын ерөнхий байцаагчийн баталсан 2023 оны 02-00/12 дугаар удирдамжаар төлөвлөгөөт хяналт шалгалт, Салбарын хяналтын газрын ерөнхий байцаагчийн баталсан 2023 оны 02-00/05, 02-00/06, 02-00/06 дугаартай удирдамжаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, салбарын ерөнхий байцаагчийн болон улсын ахлах байцаагчийн баталсан 43 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай удирдмжийн хүрээнд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай, Газрын тухай, Хот байгуулалтын тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, Геодези зураг зүйн тухай, Хаягжуулалтын тухай, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хийж холбогдох арга хэмжээг авсан.

Газрын кадастрын мэдээллийн санд нийт 1,900,666 өргөдөл бүртгэгдсэнээс шинээр газар өмчлөх 40348, шинээр газар эзэмших хүсэлт 57734, шинээр газар ашиглах 190, газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх 24644, барьцаанд бүртгүүлэх, чөлөөлөх хүсэлт 14615, газрын зориулалт өөрчлөх 430, эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах 4482, талбайн хэмжээ өөрчлөх 3124, төрөөс нөхөн олговортойгоор эргүүлэн авах 1168, эзэмшил газраа хэсэгчлэн шилжүүлэх 3122, газрын эрх дуусгавар болгох 419, шүүхийн шийдвэрээр эрх цуцлах ба сэргээх 82, эзэмшил газраа нэгтгэх 353, газрын байршил өөрчлөх 966, газрын кадастрын мэдээллийн санд нөхөн бүртгүүлэх 144960, хамтран эзэмшигч нэмэх, хасах 134 хүсэлтийг тус тус хүлээн авч бүртгэсэн байна.

Газрын маргаан зөрчил 3572 гарснаас газар эзэмшихтэй холбоотой 1676 /46.9%/, газар өмчлөхтэй холбоотой 638 /17.9%/, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэстэй холбоотой 1005 /28,1%/, газар ашиглахтай холбоотой 253 /7%/ маргаан тус тус гарсан байна.

Улсын хэмжээнд 14296 газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байна. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан судалгаагаар 34828 өмчийн газраа банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байх ба нийт 49124 нэгж талбар /газар эзэмших эрх, өмчийн газар/ буюу Монгол улсын нийт нэгж талбарын 3.8 хувийг банк, санхүүгийн байгууллага болон иргэн, хуулийн этгээдэд барьцаалсныг бүртгэсэн байна.

Газрын биржийн цахим системд нийт 8456 газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээ бүртгэсэн. Бүртгэгдсэн газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээнээс гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 6652, худалдаа үйлчилгээний зориулалттай 560, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай 1121, хөдөө аж ахуйн газраас бусад үйлдвэрлэлийн зориулалттай 122 үнийн мэдээ тус тус эзлэж байна.

Улсын хэмжээнд 2023 онд 2,957 удаа газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулснаас 1,246 дуудлага худалдаа хүчинтэй буюу 2,938.2 га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлжээ. Энэ нь өмнөх оныхтой харьцуулж үзвэл газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан тоо 1,268-аар, эзэмшүүлсэн газрын хэмжээ 4801.3 га-гаар, Улсын төсөвт оруулсан орлогын хэмжээ 19 тэрбум төгрөгөөр буурсан байдалтай байна.

Улсын хэмжээнд нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газрын нэгдмэл сангийн ангиллын газарт нийтдээ 105575 байршилд 5641.2 мянган га газар төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар нийт 57087 байршилд 4992.1 мянган га газрыг өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Монгол Улсын газрын нэгдмэл санд хөдөө аж ахуйн газар 134076.2 мянган га буюу 85.7 хувь, хот, тосгон бусад суурины газар 1232.6 мянган га буюу 0.8 хувь, зам, шугам сүлжээний газар 869.9 мянган га буюу 0.6 хувь, ойн сан бүхий газар 18211.1 мянган га буюу 11.6 хувь, усны сан бүхий газар 2022.0 мянган га буюу 1.3 хувийг тус тус эзэлж байна.

Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайлангийн дүнг 2022 оны дүнтэй харьцуулахад хөдөө аж ахуйн газар 214.5 мянган га-аар хасагдаж, хот тосгон, бусад суурины газар 203.7 мянган га, зам, шугам сүлжээний газар 10.8 мянган га-аар тус тус нэмэгдсэн байна. Ойн сан бүхий газар, усны сан бүхий газарт өөрчлөлт ороогүй байна.

Улсын тусгай хэрэгцээний газрын нийт хэмжээ 32 сая 237 мянган га талбай буюу улсын нийт нутаг дэвсгэрийн 20.6 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оныхоос 3.94 хувиар өссөн байна.

Улсын хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 1233706 нэгж талбар буюу 3058825.59 га газрыг иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгоод байна. Үүнээс 626066 нэгж талбар буюу 62139.22 га газрыг өмчилж, 599845 нэгж талбар буюу 2236739.36 га газрыг эзэмшиж, 17882 нэгж талбар буюу 759947.01 га газрын ашиглаж байна

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу 2023 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд өссөн дүнгээр нийт 723515 иргэний 71 мянган га газрын өмчлөх эрхийг баталгаажуулсан байна.

Газрын төлбөрийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш газрын төлбөрийн орлогоос 1 их наяд 178 тэрбум 897 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт

төвлөрүүлэхээр төлөвлөснөөс өссөн дүнгээр нийт 1 их наяд 97 тэрбум 269 сая төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд 1998 онтой харьцуулж үзэхэд 2023 оны газрын төлбөрийн орлого 92.2 дахин нэмэгдсэн байдалтай байна

Улсын хэмжээнд 2023 онд нийт 8,344,269.1 га газарт хохирол учруулсан дүн гарсан бөгөөд тариалангийн газрын 82,774.5 га, бэлчээрийн газрын 8,115,677.6 га, хот, тосгон, бусад суурины газрын 17,570 га, зам, шугам сүлжээний газрын 16,874.9 га, ойн сан бүхий газрын 110,930.6 га, усны сан бүхий газрын 441.5 га газарт тус тус хохирол учруулсан байна.

Улсын хэмжээнд нийт 3,895,754.16 га газарт хамгаалах, нөхөн сэргээсэн арга хэмжээг авсан бөгөөд тариалангийн газрын 205,924 га, бэлчээрийн газрын 3,540,136.29 га, хот, тосгон, бусад суурины газрын 23,275.3 га, уурхайн эдэлбэр газрын 1,790.5 га, зам, шугам сүлжээний газрын 55.74 га, ойн сан бүхий газрын 98,544.86 га, усны сан бүхий газрын 26,020 га, улсын тусгай хэрэгцээний 8 га газарт хамгаалах, нөхөн сэргээсэн арга хэмжээг тус тус авсан байна

## **ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**